Харин ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт Эдийн засгийн хүрээний гэмт хэргүүдийг тодорхойлсон бөгөөд дотроо Өмчийн эсрэг, Эдийн засгийн хүрээний болон өмчлөх эрхийн, бизнесийн байгууллагын эрх ашгийн эсрэг гэмт хэрэг гэсэн дэд бүлгүүдэд хуваан оруулсан байна.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн дагуу дампуурлын гэмт хэргийг эдийн засгийн гэмт хэрэгт хамруулан тус хуулийн 22 дугаар бүлэгт оруулсан бөгөөд Дампуурлын үе дэх хууль бус ажиллагаа (195 дугаар зүйл), Зориудаар дампуурах (196 дугаар зүйл), Хуурамчаар дампуурах (197 дугаар зүйл) гэсэн бие даасан гэмт хэргүүдийн шинжийг хуульчлан тодорхойлсон байдаг.

Эдгээр гэмт хэргүүдийн шинж нь хэллэг болон агуулгын хувьд манай орны Эрүүгийн хуулиар зохицуулсантай ижил бөгөөд дампуурлын буюу төлбөрийн чадваргүй нөхцөл байдал үүссэн үед эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийн хэмжээ, байрлалын мэдээллийг нуусан, бусдад шилжүүлсэн, нягтлан бодох бүртгэл, холбогдох баримт бичгийг нуусан устгасан зэрэг үйлдлүүд хийсэн, энэ нь дампуурлын үед төлбөрийн үүргээ төлөхөөс зайлсхийх зорилгоор хийгдсэн байх шинжийг багтаасан байдаг.⁴²

⁴¹ ХБНГУ-ын Эрүүгийн хууль /орчуулга/ 1871 он. Шинэчилсэн найруулга 2019 он

⁴² ОХУ-ын Эрүүгийн хууль /орчуулга/ 1996 он. Шинэчилсэн найруулга 2021 он.

Дүгнэлт. Эрх зүйн адил төстэй тулгамдсан асуудлыг гадаад улс орнуудад хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх нийтлэг болон ялгаатай шинжүүдийг тодруулж, үр дүнг үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхэд зохистой хэлбэрээр ашиглахад харьцуулсан эрх зүйн судалгаа зайлшгүй хэрэгтэй ба Монгол Улс эрх зүйн орчиндоо Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоо оновчтой тодорхойлох шаардлагатай.

Эдийн засгийн гэмт хэрэг тэр дотроо зориуд, зохиомлоор үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд цаг хугацаа ихээр шаардагдахаас гадна нотлох баримтыг олж илрүүлэх, бэхжүүлэх ажиллагааг цаг алдалгүй түргэн шуурхай зохион байгуулахад эдийн засгийн мөрдөгч нарын ажлын туршлага, мэдлэг чадвар зэргээс хамаарч ихээхэн хүндрэлтэй байна.

Санал:

- Эдийн засгийн гэмт хэргийг шалгаж байгаа эдийн засгийн мөрдөгч нар нь эдийн засгийн мэдлэгийн хувьд маш сайн байх шаардлага тавигдаж байгаагийн хэрээр мөрдөгч нарын сургалтыг чанарын өндөр төвшинд Эдийн засгийн чиглэлийн их дээд сургууль болон аудит, хяналтын газартай хамтран сар, улирал тутамд зохион байгуулж хэвших.

- Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль, Цагдаагийн ерөнхий газар, Авилгатай тэмцэх газартай хамтран эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх чиглэлээр хичээлийн хөтөлбөр боловсруулах, тусгайлан бэлтгэсэн боловсон хүчинг өөр чиглэлийн алба, газар, хэлтэст томилохгүй зөвхөн эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх чиглэлээр ажиллуулах хэрэгцээ шаардлагатай байна.

- Зорид зохиомлоор дампуурах гэмт хэрэг үйлдсэн этгээд нь ажилчин ангийн олон хүмүүсийг ажилгүй болгох, нийгмийн тэгш бус байдлыг бий болгох, ажил олгогч, ажил горилогч талын хоорондын харилцаанд үл ойлголцол бий болгох, дампуурсан аж ахуйн нэгжийн ажилчдын цалин хөлсийг төлөхгүй байх, нийгэмд ядуурлыг бий болгох гээд олон сөрөг нөлөөг дагуулдаг бөгөөд бусдад ямар хэмжээний хохирол учруулснаас үл харгалзан ялын санкц нь Монгол улсын эрүүгийн хуулийн 18.10 дугаар зүйлд “...гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүндрүүлэх нөхцөлөөр хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Харин ОХУ-д 2-5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар, ХБНГУ-д хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол 2-5 жил хүндрүүлэх нөхцөлтэйгээр тухайн гэмт хэргийг үйлдсэн бол 10 хүртэлх жилээр хорих ял шийтгэдэг байна. Иймд Монгол улс энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд ялын санкцийг нэмж 2-5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэхээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналтай байна.

Ашигласан ном зүй

- Эрүүгийн хууль /2002 он/
- Эрүүгийн хууль /2017 он/
- ОХУ-ын Эрүүгийн хууль /орчуулга/ 1996 он
- ХБНГУ-ын Эрүүгийн хууль /орчуулга/ 1871 он
- Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо /ФАТФ/
- <https://www.slideshare.net/GanzorigMy/ss-131135575>

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч Б.Батцэрэн*

Товч агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлийн зарим асуудлыг авч үзсэн болно.

Түлхүүр үг: Гэр бүлийн хүчирхийлэл, харгис хэрцгий харьцах, догшин авирлах, дундын болон хуваарьт хөрөнгө, захиран зарцуулах

Оршил. Дэлхийн бараг бүх улс оронд эцгийн эрхт ёс ноёрхож байгаатай холбоотой хүчирхийлэл ялангуяа эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл байсаар байна. Манай нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл урьд нь байсан, одоо ч хэвээр байна. Олон улсын судалгаагаар хүчирхийллийн 98%-ийг эрүүл хүн, 2%-ийг сэтгэцийн өвчтэй хүн үйлддэг ба нийт хүчирхийллийн 95%-ийг эрчүүд үйлддэг байна.⁴³

Монгол Улсад Гэр бүлийн хүчирхийллийг хүч давамгайлсан буюу 90 хувийг эрчүүд үйлддэг. Үлдсэн 2-8 хувийг эмэгтэйчүүд үйлддэг (*Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 93.3 хувь нь эмэгтэйчүүд байна.*⁴⁴ *Нарийвчилбал эхнэр 66, хамтран амьдрагч 24, төрсөн хүүхэд 7, дагавар хүүхэд 4 хохирчээ*). Хүчирхийллийг биеийн хүчирхийлэл (алгадах, цохих, үсдэх, зодох, гэмтээх, амь насыг хөнөөх зэрэг), сэтгэл санааны хүчирхийлэл (нэр хоч өгч, үгээр доромжлох, өндөр дуугаар загнах, хардаж сэрдэх, мөрдөн мөшгөх) мөн бэлгийн хүчирхийлэл (хүчиндэх, хувцас тайлах, эрх мэдлээ ашиглан бэлгийн таагүй байдал үүсгэх, биеийг үнэлэн худалдах) гэж ангилан хуваадаг.

Биеийн ба бэлгийн хүчирхийлэл нь гол төлөв айл, хөрш, ах дүү хамаатан садан зэрэг гэрчтэй байдаг бол сэтгэл санааны хүчирхийлэл нь тогтмол, байнгын үргэлжилж, далд явцтай байдгаараа илүү хортой.

Хүчирхийлэл нь гэмт хэрэг бөгөөд нийгмийн болон эрүүл мэндийн асуудал болсоор байна. Удаан хугацаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүд сэтгэл санаагаар хямарсан, толгой өвдөмтгий, нойронд муу, хоолны дуршил өөрчлөгдсөн, даралт хисэх эсвэл буурах хандлагатай, зүрхээр нь хатгуулж өвддөг, анхаарлаа төвлөрүүлэх чадвар муутай, ой тогтоолт нь буурсан шинжүүдийг агуулдаг бөгөөд зарим нь зүрхний шигдээс, сэтгэцийн гүн хямрал, бамбай булчирхайн хордлого зэрэг өвчтэй болж, эрүүл мэндээрээ хохирч байдгаас гадна богино насалдаг зүй тогтолцоотой. Зарим нь амь насаа өөрсдөө хөнөөхөд хүрдэг тохиолдлууд ч бий. Үүнд:

“Монгол Улсын Үндсэн Хууль”-д Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална. 16-р зүйлийн 16.13-д Монгол Улсын иргэнхалдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжин баривчлах, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд ч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий ханлаж, нэр

⁴³ www.МОНГОЛНД.mn

⁴⁴ <https://police.gov.mn/>

төрийг нь доромжилж болохгүй. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална. 16-р зүйлийн 16.18-д улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оргин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Галаалал явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журамыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно⁴⁵ гэж Монгол Улсын Үндсэн хуулинд иргэний баталгаатай эдлэх эрхийг заасан нь хүнийг эрхийг хангах чухал заалт болсон юм. Энэхүү эрхийг хангах, гэр бүл дэх хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүднээс 2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” баталсан.

Мөн хүний эрхийг түгээмэл тунхаглалын 2-р зүйлд Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй. *3 дугаар зүйл:* Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.

Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьсны өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.

2002 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн 91-р зүйл Хүнийг санаатай алах, 94-р зүйл Бусдыг болгоомжгүй алах, 95-р зүйл Бусдыг амиа хорлоход хүргэх, 96-р зүйл Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, 98-р зүйл Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах, 99-р зүйл Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах, 100-р зүйл Тарчлаах, 109-р зүйл Хүнийг хууль бусаар хорих, 114-р зүйл Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах, Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах, 116-р зүйл Хүүхэд солих, хууль бусаар үрчлэх, 117-р зүйл Хүүхэд хаях, төөрүүлэх, 118-р зүйл Асран хамгаалах үүргээ урвуулах, 119-р зүйл Сургуулийн өмнөх насны хүүхдийг халамжлах үүрэгт ажилдаа хайнга хандах, 120-р зүйл Эцэг, эх, эхнэр, нөхөр төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх, 121-р зүйл Хүүхдийг албадан болох чүхээр хөдөлмөрлүүлэх, 122-р зүйл Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, 124-р зүйл Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, 125-р зүйл Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 126-р зүйл Хүчиндэх, 127-р зүйл Эмэгтэй хүнийг тулган шаардаж үр хөндүүлэх зэрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрхийг хамгаалаад зогсохгүй гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга зам бий болж, хүчирхийлэл үйлдэгч нарт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл хэмжээг тогтоож, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдүүдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын тогтолцоо бүрдсэн ч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох,

⁴⁵ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

түүнийг бууруулах хяналтын байгууллага / цагдаагийн байгууллагаас бусад /төдийлөн анхаарал хандуулахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд 5-р зүйлийн 5.1.1-д Аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсвэл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл эс үйлдэхгүйг хэлнэ⁴⁶ гэж заасан.

Дээрхий хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэж тодорхойлсон нь учир дутагдалтай гэж бид үзэж байна. Учир нь гэр бүлийн хүчирхийллийн дийлэнхи хувь нь бие махбодийн хүчирхийллийн хэлбэрээр үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийллийн хүнд хэлбэр бөнөөд энэ үйлдэл нь даамжирч Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг болох тохиолдол түгээмэл байдаг. Өөрөөр хэлбэл зарим тохиолдолд гэр бүлийн хүчирхийллийн илрэн гарах гадаад хэлбэр нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгдэх явдлаар илэрдэг.

Гэр бүлийн хүчирхийллийг дараах шинжээр нь эрх зүйн зөрчлийн нэг төрөл гэж үзэж болно. Үүнд: Гэр бүлийн хүчирхийлэл нь үйлдэл, эс үйлдэхгүйгээр илэрнэ. Гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэл санааны дарамт үзүүлсэн болон зодох, цохих, эсвэл үл хайхрах хэлбэрээр илэрнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хэд хэдэн төрөл байх бөгөөд түүнийг судлаачид сэтгэл санааны, бие махбодийн, бэлгийн, эдийн засгийн гэсэн дөрвөн төрөлд хуваан авч үзсэн бөгөөд ингэж ангилах шалгуур үзүүлэлтийг нь тогтоогоогүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн харилцаан дахь дарамт, шахалт үзүүлэх, зодох занчих, айлгах зэрэг хэлбэрээр үйлдэгдэж буй хүчирхийлэл нь хүний өөрийн үнэлэмжийг бууруулж, улмаар хүчирхийлэлд өртөгс хүчирхийллийн шалтгааныг өөрөөсөө хайн, эцэст нь амьдралынх нь хэвийн үзэгдэл болтлоо дасан зохицдог байна.

Тухайлбал. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс хэт болгоомжлох, аргадах, уучлах, айж ичсэний улмаас тухайн нөхцөл байдлыг хууль хяналтын байгууллагад мэдээллэхгүй байх нь олон тохиолддог. Өөрөөр хэлбэл тухайн нөхцөл байдалд өөрийгөө аюул заналаас хамгаалж болохуйц аль тохиромжтой аргыг хэрэглэдэг болох нь судалгаанаас ажиглагдаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн энэ байдал нь хөндлөнгийн нүдээр харахад хохирогч өөрөө буруутай, хүчирхийлэл үйлдэгчийг өөгшүүлж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх талтай ч тэрээр гэр бүлийн хүчирхийллийн мөн чанараас шалтгаалан өөрийгөө хамгаалахаар хэрэглэж буй арга юм.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага бүртгэдэг болсноос хойш 2017 онд 3412, 2018 онд 5827 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.⁴⁷ Харамсалтай нь энэ тоо жил бүр өсөх хандлагатай байгаа бөгөөд өнгөрсөн гурван жилийн дотор 63 эмэгтэй ойр дотныхоо хүний гарт амиа алдсан гэсэн судалгаа гарсан нь сэтгэл эмзэглүүштэй. Энэ бол гурван сая гаран цөөхөн хүн амтай оронд өндөр тоо гэдгийг онцгой анхаарах цаг болсны дохио.

Баримт 1: Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчийн 86.6 хувь нь эмэгтэйчүүд байдаг. Насны хувьд 18-34 насны эмэгтэйчүүд хүчирхийлэлд хамгийн их өртсөн байна. Өөрөөр хэлбэл 25-34

⁴⁶ Төрийн мэдээлэл. 2017. №5: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.УБ.,2016.5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэг

⁴⁷ Монголын Криминологчдийн холбоо.Гэмт хэргийн цагаан ном.УБ.,2018.56 дахь тал.

насны эрчүүд эхнэр, хүүхэд, хадам ээж, ааваа хүчирхийлдэг нь тогтоогджээ. Хүчирхийлэгчдийн боловсрол, нийгмийн байдлын хувьд авч үзвэл дийлэнх нь дээд боловсролтой, ажилгүй байдаг аж. Мөн тэд эхнэр, хүүхдээ дарамталж байхдаа ихэнх нь согтуугаар үйлдэгддэг байна.

Хүүхдийн хүчирхийллийн асуудал нь гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд багтдаг ойлголт учир түүний талаар товч дурдвал.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салалт, түүнээс улбаалан хүүхэд өнчрөх, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох зэрэг нийгэмд олон сөрөг үр дагавар бий болгож байна. Монгол Улсын хэмжээнд шүүхээр гэрлэлтээ цуцлуулсан нийт тохиолдлын 58.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс болжээ.

Баримт2: 2015 онд улсын хэмжээнд 17,586 гэрлэлтийг бүртгэж байсан бол 3873 гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ. 2016 онд 16,778 гэрлэлт бүртгэгдсэн бол 4003 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан, 2017 онд 20,470 гэр бүл гэрлэлтээ батлуулж байсан бол 3945 гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ, тэгвэл 2018 онд 21,020 гэрлэлтийг бүртгэж байсан бол 4201 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна.⁴⁸

Мөн халамжийн болон асрамжийн байгууллагад хүмүүжиж буй 2000 орчим хүүхдийн 60.5 хувь нь ядуу зүдүү бйдлаас, 22 хувь нь эцэг эхийн дарамтаас, 11.8 хувь нь гэр орон дахь архидалт, ажилгүйдлээс болж гэрээсээ дайжсан, ял эдэлж байгаа хүүхдүүдийн 42 хувь нь үе тэнгийхний дарамтаас, 22 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс, 10 хувь нь сургууль дээрх таагүй харилцаанаас үүдэн гэмт хэрэгт холбогдсоны гол шалтгаан нь гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн таагүй уур амьсгалаас болжээ.

Монгол улс эрт үеэс эрэгтэй хүнийг хүндэлж, эцгийн эрхт ёс давамгайлдаг байсан энэ уламжлал өнөөгийн нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл болон хувирсан нь харамсалтай.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд нөхөр болон хамтран амьдрагчийнхаа эрүүл мэндэд хохирол учруулах бүр цаашлаад амь насыг нь хохироож, гэмт хэрэгт холбогдсон эмэгтэйчүүд олон байдаг. Өнөөдрийн байдлаар багагүй эмэгтэйчүүд дээрх шалтгааны улмаас хорих ял эдэлж байна.

Дээрх гэмтэлд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 99-р зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа ч энэ төрлийн хэргүүд ихэвчлэн хохирогч яллагдагчтай эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болж байгаа нь хүчирхийлэл үйлдэгчийн хууль бус үйлдлийг бүрэн зогсоож чадахгүй байна.

Мөн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд цагдаагийн байгууллагад хандахаас ичих, хүчирхийлэл үйлдэгчээс айсны улмаас зохих байгууллагад мэдэгдэлгүй орхих, тэвчиж өнгөрөөх тохиолдол түгээмэл байгаа бөгөөд хүчирхийллийн эсрэг төвийн хийсэн судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн таван хүн тутмын нэг нь цагдаагийн байгууллагад ханддаг нь гэр бүлийн хүчирхийллийг нуугдмал байдалд оруулсаар байна.

Нөгөө талаар цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх болон хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах дүрэм журам байхгүйтэй холбоотой байж болох юм. Ихэнхи тохиолдолд цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ “Энэ бол гэр бүлийн хоорондын

⁴⁸ Монголын Криминологчдийн холбоо. Гэмт хэргийн цагаан ном.УБ.,2018.64 дахь тал.

асуудал” гэдэг шалтгаанаар шалгахгүй орхих, захиргааны арга хэмжээ авах төдийнхөөр өнгөрөөдөгтэй холбон үзэж болох юм.

Зарим тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг шүүх цагдаагийн байгууллагад өгөхөөс илүү зан үйлийг засаж авахыг хүсдэг. Ийм учраас өдөр бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж байдаг цагдаагийн байгууллагын чиг үүрэгт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тодорхой заалт оруулах, гэр бүлийн хүчирхийлэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээг хүчирхийллийн талаар ойлголттой болгох зэрэг асуудал цагдаагийн байгууллагын өмнө тулгамдаж байна.

Мөн түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа явуулж байгаа цагдаагийн байгууллага болон бусад чиг үүрэгтэй байгууллага түүний алба хаагч, ажилтнууд нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, илэрсэн хүчирхийллийн үйлдлийг шалгаж холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, хуулийн хариуцлага хүлээлгэх явдал харилцан адилгүй, хүчирхийлэлтэй тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа нь тогтмолжоогүй жигд бус байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл буурахгүй байх, хүчирхийлэл үйлдэж байгаа арга, үйлдлийн зорилго, сэдэлт нь улам бүр олныг цочроох болж, жил бүр өсөн нэмэгдэх шалтгаан болж байна.

Хууль хяналтын байгууллагын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны алдаа дутагдлаас болж хүчирхийлэлд өртөж амиа алдах, хүчирхийллийг бүртгэхгүй байх, зохих арга хэмжээ авалгүй орхих сөрөг явдал гарсаар байгаа билээ. Тухайлбал, Өнгөрсөн 2012 онд үйлдэгдсэн ноцтой хэргийг эргэн санъя.

Баримт3: *Хохирогч 23 настай Г нөхрийнхөө гарт олон удаа хутгалуулан амь насаа алдсан хэрэг. Хохирогч нь нөхөртэйгээ гэрлэсэн цагаасаа нөхрийнхөө байнгын дарамт, хүчирхийлэл дор амьдарч байсан бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг төвд хандаж Баянзүрх дүүргийн шүүхэд гэрлэлтээ цуцлуулах, өргөдөл болон нөхрийнхөө эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулахаар хүссэн байна. Гэтэл шүүх түүний хүсэлтийг үл хайхарч хоёр сарын эвлэрүүлэх хугацаа өгсөн байдаг.*⁴⁹

Мөн хохирогчийн “амь нас, эрүүл мэндэд нь аюул учрах өндөр эрсдэлтэй” гэдгийг тогтоосон нөхцөл байдлын үнэлгээг Сүхбаатар дүүргийн нэглсэн эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний нийгмийн ажилтан хийсэн, тэр нь хавтаст хэрэгт авагдсан атал шүүгч шийдвэр гаргахдаа хариуцагч М нь айлган сүрдүүлж, орой үдэш мөрдөж байгаа гэдэг байдал нь гэм хор учруулах, учруулахаар заналхийлсэн үйлдэл гэж үзэх боломжгүй” гэсэн үндэслэлээр хохирогчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгожээ.

Мөн нөхөртөө зодуулчихаад цагдаагийн 102 дугаарын утсанд хэд хэдэн удаа дуудлага өгсөн ч дуудлага авсан цагдаагийн албан хаагч дуудлагын дагуу очоогүй зэрэг олон алдаа дутагдал давтагдаж байгааг арилгаг цаг нэгэнт болжээ. Иймд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг бүхий цагдаагийн байгууллага, түүний алба хаагч, суё баг хороны засаг, нийгмийн ажилтан нарын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын үр нөлөөг сайжруулах, тэднийг сургаж, дадлагажуулах, үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай санхүүгийн боломж нөхцлөөр нь хангах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн байгууллагын харилцан ажиллагааг сайжруулж хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг бүхийн албан хаагч, ажилтнууд

⁴⁹ <http://www.shuukh.mn/Г-д> холбогдох гэмт хэргээс.

нь биелүүлбэл зохих үүргээ биелүүлээгүй, хайнга хандсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгоход онцгой анхаарах шаардлагатай байна.

Бидний үзэж байгаагаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд албадлагын шинжтэй, эрх хязгаарлах, гэр бүл цуцлах, захиргааны шийтгэл оногдуулах зэрэг арга хэмжээ авахаас илүүтэйгээр хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг засах арга хэмжээг түлхүү явуулбал хүчирхийлэлтэй тэмцэх ажил илүү үр дүнд хүрэн боломжтой байж болох юм. Тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн нас хүйс, ажил мэргэжил, боловсрол, өссөн орчин, найз нөхөд, гэрлэлтийн түүх, хувь хүний хүмүүжил, зан төрх, ахуй амьдрал, үйлддэг хүчийрхийллийн хэлбэр зэргийг харгалзан үзэж сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын эмчилгээ хийх зэрэг арга хэмжээг түлхүү авах шаардлагатай гэж үзэж байна.

Ингэхийн тулд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх анхан шатны нэгж болох хамтарсан багийн бүрэлдэхүүнд “сэтгэл зүйчийг” нэмж оруулан үйл ажиллагааны төлөвлөгөө, арга зүйг боловсруулж ажиллавал хүчирхийлэлтэй тэмцэх ажилд ахиж гарах бас нэг алхам болно.

Зарим тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа нь үр дүнд хүрэхгүй байх, хүчирхийллийн эсрэг авсан хариу арга хэмжээ нь хүчирхийлэл үйлдэгчид нөлөөлөхгүй байх, хүчирхийллийн тоо буурахгүй байх, хүчирхийллийн хэлбэр илүү хүнд хэлбэрт шилжих, давтамж ихсэх, түүнчлэн хууль хяналтын байгууллагад мэдэгдсэнээрээ хүчирхийлэгчийг улам догшруулах, өс хонзон санах зэрэг сөрөг нөхцөл байдал үүсгэдэг учир хүчирхийлэл үйлдэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл засах эмчилгээ хийснээрээ энэхүү ажил үр дүнд хүрч болох гол арга зам гэж бид үзэж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх:

Дээрх гэмт хэргийн халдлагад өртөгч (хохирогч)-ийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байхаар тусгайлан хуулийн тайлбарт заасан бөгөөд гэмт хэргийн объектив талыг дэлгэрэнгүй байдлаар зааж өгсөн. Тухайлбал, практикт түгээмэл үйлдэгддэг эхнэр, нөхрөө “хардаж” зодох, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох байдлаар бие махбодийн, сэтгэл санааны зовиур шаналал байнга учруулдаг, тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох боломж бүрдэнэ.

2016 оны 12-р сарын 22-ний өдрийн Монгол Улсын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” шинэчлэн найруулсан хууль батлагдсантай холбоотой тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулинд дээрх өдөр **“120¹ дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”** нэмэлт өөрчлөлт орж анх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг гэмт хэрэг гэж хуульчилсан. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн **11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг гэдэгт:** Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол үндсэн бүрэлдэхүүнд, гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн, асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн, таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол хүндрүүлэхээр хуулчилсан. Гэмт хэргийг хохирогчийг байнга зодож, харгис хэрцгий харьцаж, тохуурхан даажигнаж, тарчлаах шинжтэй бусад үйлдэл хийж, догшин авирлаж, хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг, энэ гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан.

Энэ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд зорчих эрхийг хязгаарлах ялын төрлийг шинээр нэмж, хорих, баривчлах ялыг хассан. Уг гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй тодорхойлсон. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодож эрүүл мэндэд нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан тохиолдолд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг тохирох зүйлээр зүйлчилж, ял оногдуулна.

Үндсэн бүрэлдэхүүнд 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, 1-3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр, хүндрүүлэх бүрэлдэхүүнд 3-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр тус тус хуульчилсан.

Дүгнэлт, санал.

Сүүлийн үед Цагдаагийн байгууллагын мэдээлэлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн тоо тогтмол өсөж байгаа боловч практикт тухайн гэмт хэргийн зүйлчилхэд хүндрэлтэй асуудал байсаар байна. Үүнд:

- 2015 онд батлагдаж 2017 оны 07-р сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг байнга үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Байнга гэдэг нь тоо шинж, давтамж заасан бөгөөд одоогийн Эрүүгийн хуулианд байнга гэсэн үгийн утгаа тайлбарлаагүй, мөн энэ талаар Улсын Дээд Шүүхийн албан ёсны тайлбар гаргаагүй харин өмнөх буюу 2002 оны 01-р сарын 03-ний өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн 16-р бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд Шүүхийн 2010 оны 05-р сарын 19-ний өдрийн № 13 тоот тогтоолын 9. Хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-д заасан “байнга зодох” гэж тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа бие махбодийн хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ...гэсэн тайлбарыг одоогийн хуулийг зүйл заалтыг тайлбарлахдаа ашиглаж байгаа нь буруу юм. Гурав буюу түүнээс дээш удаагийн давтамжтай үйлдсэн тохиолдолд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг болно гэсэн тайлбар одоогоор хууль болон албан ёсны тайлбарт байхгүй байна.

- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодож эрүүл мэндэд нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учруулсан тохиолдолд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг тохирох зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх зүйлээр давхар зүйлчилж, ял оногдуулах.

- Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэдгийг “Иргэний хуул”-ийн **108 дугаар зүйл Дундын өмч** 108.3.Дундаа хэсгээр өмчлөгч бүр ногдох хэсгээ бусдын өмчлөлд шилжүүлэх буюу өөр байдлаар захиран зарцуулах эрхтэй бөгөөд ийнхүү захиран зарцуулахдаа хэсгээр өмчлөгч бусад өмчлөгчдөд мэдэгдэх үүрэгтэй...гэж заасан байна. Амьдрал дээр нөхөр, эхнэрээ архи согтууруулах ундааны зүйл гадуур хэрэглээд гэртээ ирхэд нь хаалга тавихгүй агсан, согтуу тавиад байна гэх мэтээр тухайн иргэнийг Цагдаагийн байгууллагад мэдэгдэж дундын өмчөө захиран зарцуулах эрхэд нь халдах явдал нилээдгүй байдаг дундын өмчтэй холбоотой “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг захиргааны зөрчил, гэр бүлийн маргаан гэх мэтээр буруу ташаа бүртгэгдэж энэ төрлийн гэмт хэрэг алба хаагчдын эрх зүйн мэдлэг тутмаг болон бусад байдлаас болж ял завшиж байгааг анхаарах нь зүйтэй.

ГЭМТ ХЭРЭГТ СЭЖИГЛЭГДЭЖ БУЙ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ

*Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗ-ийн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн хошууч Б.Батзаяа*

Товчлол: Нийгмийн хамгааллын салбарын бодлого болон эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2012-2016 онд хүүхэд хамгааллын бодлогыг шинээр тодорхойлж, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг УИХ-аас батлан гаргаж, 2016 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хүүхэд эрх, хүүхэд хамгаалал нь зөвхөн дээрх хоёр хуулиас гадна эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан эрүүгийн багц хууль тогтоомжтой уялдан боловсруулагдсан байдаг.

Хууль сахиулагчдаас орчин үеийн хүүхдийн хөгжлийн болон сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэгийг эзэмших хэрэгтэй гэж үздэг болсон бөгөөд энэхүү өгүүлэлд гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хүүхдийн эрх ашгийг дээдлэх үзэл хандлага төлөвшүүлэхэд анхаарах зарим асуудлын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн сэтгэл зүй, сэжигтэн хүүхэд, гэмт хэрэг,

Үндсэн хэсэг: Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж, гэр бүл түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстойг ойлгож, Монгол улс “Хүүхдийн Эрхийн Тухай” конвенцийг 1990 оны 7 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталж, улмаар 1990 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Энэхүү конвенцид нэгдэн орсноор хүүхдийн угаас заяасан нэр төр, эрх чөлөөг хамгаалж, энх тайван, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгод хүрэх том алхам болсон юм.⁵⁰

Цаг үеийн нөхцөл байдал, бүх нийтийн хорио цээрийн дэглэмийн үед насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэргийг ураг төрлийн хамааралтай, ойр дотны хүмүүс үйлдэж бие махбодь, сэтгэл санааны хямралд орж сэтгэцийн эмгэг үүсэх, амь насаа хорлох, эцэг, эхчүүдээс хүүхдүүдийн цахим орчны хэрэглээнд тавих хараа хяналт сул байгаагаас өөрийн аюулгүй байдлаа хангаж чадахгүйд хүрч улмаар бэлгийн хүчирхийлэлд өртөх гэмт хэргийн хохирогч болж байна.

Улсын хэмжээнд 2010-2017 онуудад цавуу, бензин, газ үнэрлэх зөрчил хүүхдүүдийн дунд нэлээд гарч байсан бол 2018 оноос хойш одоог хүртэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 10,3 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь мансуурахтай

⁵⁰ Г.Агар-Эрдэнэ, Ц.Адьяахишиг. Хүний эрхийн Олон Улсын билл. Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн Олон Улсын гэрээний эмхэтгэл. Уб. 2019. 202 дахь тал.

холбоотой бодис хэрэглэх төрөл хэлбэр нь өөрчлөгдсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэж үзсэн, хэрэглэж байгаа хүүхдийн тоо өсөх хандлагатай гэж дүгнэхээр байна.

Насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдсон тоон үзүүлэлтийг сүүлийн 10 жилээр нь авч үзэхэд нийт 11257 хэрэг, жилд дунджаар 1125 хэрэг бүртгэгдэж, бүх хэрэгт эзлэх хувийн жин 3,9 хувь болж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд хулгайлах гэмт хэрэгт 2020 онд 355 насанд хүрээгүй хүн холбогдсон нь 2019 оноос 212 буюу 37,3 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 2020 онд 224 хүүхэд холбогдсон нь 2019 оноос 8 буюу 3,4 хувиар, 2020 онд хулгайлах гэмт хэрэг 355 хүүхэд холбогдсон нь 2021 оны эхний 11 дүгээр сарын байдлаар 115 буюу 32,3 хувиар тус тус буурсан тоон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16 дугаар бүлэг (Хүүхдийн эсрэг гэмт хэрэг)-т дараах гэмт хэргүүд хуульчлагдсан. Үүнд:

- 16.1 дүгээр зүйл. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах;
- 16.2 дугаар зүйл. Хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд татан оруулах;
- 16.3 дугаар зүйл. Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх;
- 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах;
- 16.5 дугаар зүйл. Хүүхэд солих;
- 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах;
- 16.7 дугаар зүйл. Хүүхэдтэй хэрцгий харьцах;
- 16.8 дугаар зүйл. Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах;
- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах;
- 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх;
- 16.11 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх⁵¹ зэрэг багтана.

Хүүхдийн эсрэг гэмт хэргүүдийн бүрэлдэхүүн дараах нийтлэг шинжтэй. Үүнд:

Объект: Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хүүхдийн эрх ашгийг зөрчиж, хохироосон байна. Тодруулбал, Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд халдсан, ёс суртахууны хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж хохироосон байна.

Объектив шинж: Гэм буруутай этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөн хүүхэд хохирсон байна.

Субъектив шинж: Хүүхдийн эрхийг зөрчсөн гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйд шууд санаатайгаар хандаж, хүүхдийн эрх, ашгийг хохироосон үр дагаварт хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, гэм буруутай этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бусыг, үүний улмаас хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж, хохирохыг мэдэж, түүнийг хүсэж, тийм үр дагаварт хүргэсэн байна.

Субъект: Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, манай улсын, гадаад улсын хоёрдмол харъяалалтай, аль ч улсын харъяалалгүй иргэн байна.⁵²

Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх болсон хүчин зүйл нь генетикийн болон хүрээлэн буй орчны хүчин зүйлийн холимог байдлаас үүдэлтэй байдаг. Өсвөр насны

⁵¹ Төрийн мэдээлэл. 2016. №7. Монгол Улсын Эрүүгийн хууль

⁵² Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. Онол, практикийн асуудал. Улаанбаатар. 2021. 94 дэх тал.

хүүхдүүдийн гэмт хэрэг үйлдэх хамгийн чухал хүчин зүйл нь эцэг эхийн хэв маяг, үе тэнгийн бүлгийн холбоо юм. Өсвөр насны хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж болзошгүй нэмэлт хүчин зүйлүүд нь санхүүгийн бэрхшээл, сургуулиас завсардсан байдал, бүтэлгүйтэл, мөн үе тэнгийнхнээсээ хөндийрөх зан үйл байдаг.

Өсвөр насандаа ганц бие эцэг эхийн гар дээр өссөн хүүхдүүд эцэг эх хоёулаа амьдардаг хүмүүстэй харьцуулбал ядууралд нэрвэгдэх, гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг.

Үе тэнгийнхнээс татгалзах нь насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх урьдчилсан бэлтгэлийг хангадаг. Өсвөр насны хүүхэд ийнхүү үе тэнгийнхнээсээ хөндийрснөөр түүний зөв нийгэмших чадварт нөлөөлж, ихэвчлэн нийгмийн сөрөг үе тэнгийн бүлгүүдэд татагдахад хүргэдэг. Өсвөр насны хүүхдийн хөгжлийн судалгаанаас харахад өсвөр насныхан эрсдэлд өртөмтгий байдаг.

Өсвөр насны хүүхэд зан авирын сөрөг хэв маягаа үргэлжлүүлсээр арван найман нас хүрмэгц эрүүгийн ноцтой гэмт хэрэгтэн болох магадлал өндөр байна. 15 наснаас өмнө зан авирын эмгэгийн түүхийг тодруулах шаардлагатай. Зан авирын эмгэг нь тогтворгүй, түрэмгий зан авиртай ижил төстэй байдаг. Тиймээс зан авирын эмгэг гэж оношлогдсон насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдийн эрт үеийн шинж нас бие гүйцсэн хойноо илэрдэг. Гэмт хэрэгтэн бие хүн бага сургуульд орохоосоо өмнө нийгмийн эсрэг зан үйл үйлдэж эхэлдэг бөгөөд тэд олон төрлийн хор хөнөөлтэй зан авир гаргадаг, бусдад маш ихээр гомддог онцлог төрх үйлийн шинж илэрдэг.

Мөн “Өсвөр насны хүнийг байцаах, шүүн таслах ажиллагаанд урьдчилан бэлтгэх, хэргийн оролцогчдын бүрэн оролцох боломжийг бүрдүүлэх, хүүхдийг байцаалтад дуудахдаа тэдгээрийн эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах ба өсвөр насны хүн ямар хэрэгт сэрдэгдэж байгааг тайлбарлаж өгөх” нийтлэг чиг үүрэгтэй.⁵³

“Хохирогч болон холбогдогч хүүхдийн мэдээллийг цагдаагийн байгууллага болон бусад этгээдээс хүлээн авсны дараа хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчтэй уулзах уулзалтыг нэн даруй зохион байгуулах” туслалцаа үзүүлнэ.⁵⁴

Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүүхдийн сэтгэл зүйн онцлог:

Сэжигтэн ч буруутгагдаж буй этгээд ч заавал хэрэгтэн байх албагүй. Иймд хэргийн гол асуудал буюу уг хэргийг тухайн этгээд үйлдсэн үү үгүй юу гэдгийг тогтоохын тулд тэдний сэтгэлзүйг маш сайн ойлгодог байх хэрэгтэй юм. Тухайлбал, сэжигтний хувьд зан байдал нь ойр ойрхон хувирч байх талтай.

Гадны цочролд хүний үзүүлэх хариу үйлдэл нь хоёр янз байдаг. Тэгвэл физиологийн хариу үйлдэл нь мөн л сэтгэлзүйн хувьд түгшүүртэй, хурцадмал байдалтай байгааг гэрчлэх бөгөөд сэжигтний нүүрний хувирал болон гарын дохио зангаагаар илэрч байдаг болно.

Мэдүүлэг авах үед буруутан этгээд сэтгэлзүйн янз бүрийн байдалд орж байж болно. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн бол илчлэгдэх, улмаар ял зэмлэлээс айж байх нь тодорхой. Энэ нь сэтгэлзүйд дарамт учруулж, сэжигтнийг ихээхэн мохоож, үүссэн нөхцөл байдлыг буруу үнэлэх нөхцөл бүрдүүлэх, бие барих чадвар алдахад хүргэж байх магадлалтай. Ингэснээр сэжигтнийг

⁵³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын А51/А69 тоот тушаалын нэгдүгээр хавсралт (2017.03.27) Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам 3.5.5.

⁵⁴ Мөн журам 3.7.

сэтгэлзүйн холбоо тогтоох явдлыг хүндрүүлж, улмаар байцаалтын тактикийн аргуудын үр нөлөөг бууруулна.

2. Мэдүүлгийн үеэр гэр бүл, ойр дотны хүмүүс, найз нөхөд болон хамт ажиллагсад нь хэргийн талаар мэдэх вий гэж айсны улмаас сэтгэлийн хямрал, ичгүүртэй байдалд орсон байж болох юм. Иймд бусдад задруулахгүй байх хүсэл нь буруутны зан байдлыг тодорхойлогч хүчтэй сэдэл болж байдаг.

3. Буруутан этгээдийн хувьд өөрийн хүрсэн нийгмийн байр суурь, албан тушаал, эд хөрөнгөө алдахаас айх явдал үндсэн шинж болж байдаг. Иймээс гэмт хэрэг үйлдсэн бол байцаалтын үеэр үнэн зөв хариулт өгөхөөс зайлсхийдэг.

4. Сэжигтний зан төлөвийг тодорхойлогч хамгийн хүчтэй сэтгэлзүйн байдлуудын нэг нь эрх чөлөө, хэвийн амьдралаа алдаж, улмаар гэмт хэрэгтнүүдтэй нэг дор байхаас айх айдас юм.

5. Сэжигтний зан төлөвийг нэлээдгүй хэмжээгээр тодорхойлогч сэтгэлзүйн байдал бол ойр дотны хүмүүсээсээ хагацахтай холбоотой сэтгэл зовнил байна. Энэ нь нэг талаас буруугаа хүлээж үнэн зөв мэдүүлэг өгөх, эсвэл эсрэгээрээ худал мэдүүлэхэд хүргэж байж болно.

6. Сэжигтний хувьд хохирогч, түүний гэр бүл, ойр дотны хүмүүсийг өрөвдөх сэтгэл төрөх нь цөөнгүй. Үүнийг нь мөрдөгч дэмжиж, бататгаж өгөх нь чухал.

7. Мэдүүлэг авах үед ихэвчлэн үүсэх хурцадмал байдлуудад сэжигтэн нэг л “зайдгай” байдалтай болж, сандарч байгаагаа дарах, мөрдөгчид “үнэнээ хэлэх” хүсэлтэй, өөрийн амьдрал, хүсэл сонирхол, азтай болон азгүй тохиол, мөрөөдөл, төлөвлөж явдаг зүйлс гэх мэтийн талаар бүхнийг биш юм аа гэхэд нэлээдийг нь ярьж өгөхөд бэлэн болсон байх магадлалтай. Энэ нь түүнийг гэмээ ухаарч, үнэн зөв мэдүүлэг өгөхөд хамгийн тохиромжтой үед байгааг илэрхийлнэ.

8. Зарим сэжигтэн цагдаагийн ажилтан, мөрдөгч, прокурор, гэрч гээд түүнийг илчлэхэд оролцож буй бүхий л хүмүүст дайсан шиг ханддаг. Сэжигтний ийм байр суурь түүнд сэтгэлзүйн зөв арга хэрэглэх явдлыг ихээхэн бэрхшээлтэй болгож байдаг.⁵⁵

Гэмт хэрэг үйлдсэн хүүхэдтэй ажиллах нь: Зарим эцэг эхчүүд хүүхдээ гэмт хэрэг үйлдсэнийг гэнэт дуулаад өөрсдөө зодож шийтгэхийг урьтал болгодог. Мөн хохирогчдын гэр бүлийнхний зүгээс заналхийлэх явдал ч гардаг. Энэ тохиолдолд хүүхдийн хамгаалуулах эрхийг хангахын тулд нийгмийн ажилтан гэр бүлийнхэнтэй нь ажиллах шаардлагатай. Хүүхэд хийсэн хэргийнхээ төлөө шаналан, ичиж эмээж өөрийгөө өөрөө шийтгэж байхад нь нэрмээс болохгүй байх талаар ойлгуулж, хүүхдийн хүчирхийлэл бол гэмт үйлдэл гэж таниулах нь зүйтэй. Хэрвээ хүүхэд, гэр бүлийн гишүүдийн хооронд энэ мэт зөрчил, маргаан байвал харилцааг сайжруулах, бие биеэ ойлгох боломж олгох зөвлөгөө засал өгөх хэрэгтэй. Мөн хүүхдийн оршин сууж байгаа хорооны хэсгийн байцаагчтай холбоо тогтоож хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар идэвхитэй алхам хийж болно.

Хэрвээ амьдралын элдэв шалтгаанаар хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр томилох хүн байхгүй бол гэрбүл хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хандаж шийдвэрлүүлж болно. Зарим тохиолдолд тухайн хэрэгт магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын ажилтныг төлөөлөн оролцуулж болно. Нийгмийн ажилтны ажил үүргийн хүрээ нэмэгдэж байгаа болохоор хуулинд өөрчлөлт оруулах хэрэгтэй болж байна. Гэхдээ нийгмийн ажилтны хийж гүйцэтгэж байгаа ажлаар нь тэднийг сурган хүмүүжүүлэгч гэж тооцож болох тул өнөөгийн хуулийн хүрээнд хүүхдийн хууль ёсны төлөөлөгч гэж тооцож болох боломжтой.

⁵⁵ Хуулийн сэтгэл зүйч, докторант Ш.Номин-Эрдэнэ. Хуулийн сэтгэл судлал. Уб. 2021

Гэмт хэргийн ул мөр дээр хүүхэдтэй ажиллаж байсан сэтгэл зүйчийн туршлагаас хуваалцахад мөрдөгч болон бусад хүнтэй контакт үүсгэхээс өмнө хамгийн түрүүнд сэтгэл зүйчийг тухайн хүүхдүүдтэй уулзуулж, сэтгэл зүйг тайвшруулж, хэвийн болгосны дараа мэдүүлэг авч байх нь хүүхдийн эрхийг хангах үндэс болно гэдгийг онцолж байна. Жишээ нь: 2021 оны 4-р сард нэгэн байрны давхараас ээж нь 3-н хүүхдийнхээ нүдэн дээр цонхоороо үсрээд амиа алдсан. Хүүхдүүд нь араас нь ээжээ гээд үлдсэн. 3-н хүүхэд нь тухайн үзэж харсан хэргийн хувьд гэрч болж байгаа юм.

Хүүхдүүд болохоор эрх, хууль ёсны ашиг сонирхолоо мэдэхгүйгээр хэрэгт ач холбогдол бүхий мэдүүлэг өгч, тухайн мэдүүлгийнх нь дагуу эцгийг нь барьж хорьсон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан. Гэтэл хүүхдүүд ирээдүйд нас биед хүрнэ, юмны учир зүй тогтлыг ойлгож эхэлнэ, тухайн үед өө бид нарын мэдүүлгээс болж аавыг маань шоронд хорьчихсон юм байна гэдэг харуусал төрөх юм. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хангахын тулд эхлээд хүүхдүүдийг сэтгэл зүйчтэй уулзуулж тайвшруулж, сэтгэл зүйг нь хэвийн болгож, түүнд хуульд заасан эрх үүргийг нь тайлбарлаж өгсөн бол ирээдүйд гарах хор уршиг багасах юм.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх нөхцөл журам, хэрэгжүүлэгч байгууллага, хэрэгжүүлэх процесс зэргийг Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуульд нарийвчлан зааж өгсөнөөр шүүхээс уг албадлагын арга хэмжээг хэрэглэх боломж бүрдэхээс гадна гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг хуульд заасан гол зорилгууд биелэх бодит нөхцөл үүснэ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулан шинээр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г байгуулахаар заасан ба уг хороо нь дараахь үйл ажиллагааг явуулахаар заасан байна:

1. Гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2. Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

3. Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

4. Хууль зөрчсөн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

5. Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

6. Хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

7. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх ашгийг хамгаалах.⁵⁶

Хүүхэд хамгааллын тухай хуульд тодорхой заасан боловч үүнийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нэгж, орон тооны бус хороодууд хэлбэрийн шинжтэй үйл ажиллагаа явуулж, нэгдсэн

⁵⁶ Төрийн мэдээлэл. 2016. №9. Хүүхэд хамгааллын тухай хууль

бодлого төлөвлөгөөтэй ажиллахгүй байгаагаас хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх нь сорилт, бэрхшээлтэй нүүр тулж байна.

Дүгнэлт: Гэмт хэргийн улмаас хүүхдэд бие махбодийн хохирлоос гадна, ёс суртахууны, эд хөрөнгийн, санаа сэтгэлийн хохирол учирдаг. Ёс суртахууны хохирол нь тухайн хүүхдийн нэр төрийг нь гутаан доромжлох, сургууль, гэр бүлийн орчинд нэр хүндийг нь унагах, сэтгэлийг нь хямрааж шаналгах хэлбэрээр илэрнэ. Энэ хохирлыг барагдуулж шийдвэрлэсэн талаарх шийдвэр баримт байхгүй байгаа юм. Энэ хохирол нь тухайн хүүхдийн хувь тавилан, цаашдын амьдралтай холбоотой байдаг тул үүнийг хамтад нь шийдвэрлүүлэхээр шүүхийн шийдвэрт тусгах нь хүүхдийн дээд эрх ашигт нийцэх юм.

Хүүхэд гэмт хэрэгт өртөж хохирсон эсхүл гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрт хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллагад хандаж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд мөн эсэх ямар тусламж үйлчилгээ шаардлагатайг тогтоолгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж байх шаардлага байна.

Мөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, сэтгэл санааны хохирлоо хэрхэн барагдуулах, түүнийг тооцох аргачлал тодорхой бус байгаа, мөн эрүүгийн болон иргэний шүүхээр олон шат дамжлага дамжиж явах нь тэднийг хохирлоо бүрэн барагдуулахад хүндрэл бэрхшээлтэй байгааг дурьдах нь зүйтэй юм.

Гэмт хэрэг үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнхи нь урьд нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хэрэг хянан ажиллагаанд татагдан оролцож, сурган хүмүүжүүлэгч гэсэн статустай болсон багш, нийгмийн ажилтан тухайн хэргийн талаархи мэдээллээс гадна хүүхдийн хувийн байдал, өвчин эмгэг ч юм уу бусад байдлаар хувь хүүхдийн нууцыг хамгаалах.

Ялангуяа сургуулийн орчинд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн талаар ямар нэг яриа, мэдээлэл гаргахгүй байхад чухалчлан анхаарч, хүүхэдтэй өөртэй нь харилцаа тогтоох, итгэл төрүүлэх, аль болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хөндийрүүлэх бодлого баримтлах нь зүйтэй.

2. Хөдөө орон нутаг, сургууль, ахуйн орчинд хүүхдийн нэр төрийг хамгаалах, амьдрах нутаг орныг нь солих асуудлыг хуулиар зохицуулсан боловч энэ эрхээ эдэлж чадахгүй байгаа хүүхдүүдийн эрхийг хэрхэн хангахыг хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтан, төрийн бус байгууллагууд хуулиар олгосон чиг үүргийнхээ дагуу мэргэшсэн, мэдрэмжтэй, санаачлагатай, хүүхдийн эрхэд суурилсан, хүүхэд төвтэй хандах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарал хандуулах.

3. Аймаг нийслэлийн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан дүгнэлтүүд нь нотлох баримтыг шаардлага хангахгүйгээс шалтгаалан хэрэг эцэслэн шийдвэрлэгдэхгүй байх тохиолдол их байх тул цаашид Улсын ерөнхий прокурортой хамтран мөрдөгч нарт сургалт зохион байгуулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын үндсэн хууль (1992)
2. Гэр бүлийн тухай хууль (1999)
3. Хүүхэд хамгааллын тухай хууль (2016)
4. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016)
5. Эрүүгийн хууль. (2017)
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хууль (2017)
7. Хүүхдийн сэтгэл зүйн ертөнц. Хишиг-Ундрах, М. УБ.2019
8. Хуулийн сэтгэл судлал. Номин-Эрдэнэ, Ш. УБ.2021
9. Б.Батзориг, Х.Баавгай, Г. Оюунболд нар, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн гарын авлага. УБ. 2017.
10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 3 дугаар сарын.27-ны өдрийн А51/А69 тоот тушаал
11. Хүүхдийн эрхийн Хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам

ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН НУУЦЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа П.Эрдэнэбаатар*

Товч утга: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалыг хангах, эрх зүйн зохицуулалт хуулийн хэрэгжилт, төр, байгууллага, хувь нууцыг хамгаалах тэдгээрийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалт, мөрдөн шалгах ажиллагаа, нууц, нууцлал, төрийн нууц, байгууллагын нууц, хувь хүний нууц, баталгаа, эрүүгийн хэргийн материал,

Үндсэн хэсэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал гэх ойлголт Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөр өөр нэр томъёогоор хуульчлан баталгаажиж, нарийвчлан зохицуулагдаагүйгээс гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, нотлох ажиллагаанд бэрхшээлийг учруулж хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдөж байна.

2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа⁵⁷, "Мөрдөн шалгах ажиллагаа" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах хуульд заасан ажиллагаа⁵⁸, Эрүүгийн хуульд "Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах"⁵⁹, харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал"⁶⁰ гэж тус тус томъёолон хуульчилсан.

Түүчлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудлын талаар хэвлэлийн эрх чөлөө ойлголтын дор хэвлэл мэдээлэл, цахим, вертуаль орчинд төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутайд тооцохгүй байх зарчим хэрэгжихгүй байна гэж үзэж болох юм.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал гэдэг нь өргөн утгаараа дараах шинжүүдийг агуулна. Үүнд:

- Мөрдөгчийн хараат бус үйл ажиллагаа явуулах нөхцөлүүд /Мөрдөгчийн ургийн овог гэрийн хаяг, албан тушаал, утас, ам бүл, эрхэлсэн албан тушаалын урьдах байдал/;

⁵⁷ Төрийн мэдээлэл. 2017. №23. ЭХХШТХ-ийн 1.36 дугаар зүйл

⁵⁸ Төрийн мэдээлэл. 2017. №23. ЭХХШТХ-ийн 1.9 дүгээр зүйл

⁵⁹ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл

⁶⁰ Төрийн мэдээлэл. 2017. №23. ЭХХШТХ 29.3 дугаар зүйл

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах ялангуяа шүүхийн өмнөх болон шатны хэвийн үйл ажиллагааг хангах боломж;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хууль ёсны эрх ашиг сонирхол, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээхэд чиглэгдэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууцалбал зохих баримтат мэдээлэл, материалыг хамгаалах, төр, байгууллага, хувь хүний нууц тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамааралтай нотлох баримтууд хамаарна. Тухайлбал, гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадлагаа, кино, ба гэрэл зураг, зураглал, дууны, дуу-дүрсний бичлэг, ул мөрнөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны тогтоол, тодорхой ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, прокурорын яллах дүгнэлт, шүүхийн шийтгэх тогтоол, эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд мөрдөн байцаалтын нууцлалыг задруулахгүй, түгээхгүй байх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримталж буй /криминалистикийн арга зүй/ тактик, стратеги, цаашид авах, арга хэмжээ баримжаалж буй чиглэл, төлөвлөлт, төлөвлөгөө, удирдамж;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа оролцогч, төр, байгууллага, хувь хүний нууц орно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилттой уялдуулан дараах байдлаар дэлгэрүүлэн авч үзвэл:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын зохион байгуулалтын бүтэц төсөв, орон тоо, холбогдох мэдээ, баримт;
- Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн талаарх баримт бичиг;
- Мөрдөгчийн ажлын төлөвлөгөө, биелэлт, ажлын тайлан, мөрдөгчийн хувийн хэрэг, үүрэг, даалгавар, албан бичгийн эх хувилбар, дэвтэр, хуудас, гэмт хэргийн талаарх танилцуулга, мэдээ, мэдээлэл;
- Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийн тоо бүртгэл, түүнд байгаа баримт бичиг, материал;
- Мөрдөн шалгах байгууллагын техник хэрэгслийн зохион байгуулалт, байршил, ашиглалтын байдал, хамгаалалт, дохиолол, хяналтын хүч хэрэгсэлтэй холбоотой мэдээ, баримт;
- Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийн эх сурвалж, түүнийг өгсөн хүний овог нэр, гэрийн хаяг болон ажлын хаяг бусад мэдээлэл;
- Эрүүгийн хэргийн хавтаст материал;
- Бусад шаардлагатай баримт, сэлт мэдээлэл гэх мэт;

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүн, хуулийн этгээдийн гэм буруутай эсэхийг урьдчилан тогтоохыг хориглоод шүүх, прокурор, шинжээч, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтанд яллагдагч, шүүгдэгчийн гэм

буруугийн талаар урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй⁶¹ гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд үл тооцож болно гэж заасан үндсэн зарчмын илэрхийлэл юм.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэг үйлдсэн, хүн, хуулийн этгээдийг олж тогтоохоор мөрдөн шалгах ажиллагаа хийгддэг тул нууцлалыг чанд сахих ёстой юм. Энэ утгаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана.

Мөрдөгч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авна. Энэ талаар төрийн нууцын тухай хуулинд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ гэж заажээ. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс зарим барилга, байгууламж, төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулж болох тухай заалт мөн бий. Төрийн нууцын тухай хуулийн дээрх заалтын дагуу Төрийн нууцын тухай жагсаалтыг батална.

Мөрдөгч нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна. Хувь хүний нууц тухай хуульд Монгол Улсын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйл гэж тодорхойлон дараах төрлүүдэд ангилан авч үзсэн байна.

- Захидал харилцааны нууц – Захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйл;
- Эрүүл мэндийн нууц – Тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээлэл;
- Хөрөнгийн нууц – Зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйл;
- Гэр бүлийн нууц – Бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл;
- Хуулиар тогтоосон бусад нууц;

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг нийтэд мэдээлэх талаар аливаа хүсэлт гарсан тохиолдолд мөрдөгч энэ тухай хэрэгт хяналт тавьж буй прокурорт танилцуулна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад төрийн нууцтай холбоотой асуудал гарвал мөрдөгч холбогдох байгууллагын удирдлагад мэдэгдэж, нууц хариуцсан албан тушаалтныг байлцуулна. "Байгууллагын нууц" гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны

⁶¹ Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг. Байгууллагын нууцад юу хамаарахыг байгууллага өөрөө тогтоодог.

Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнт зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно. Мөн байгууллагын нууцыг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн нууц: үйлдвэрлэлийн арга, технологи, шинэ техник, машин механизм, техникийг бүтээх арга, түүний давуу тал болон тендертэй холбоотой нууцууд
- Санхүү, худалдааны нууц: байгууллагын нягтлан бодох бүтгэлийн баримт бичгүүд, харилцагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн нөхцөл, бараа бүтээгдэхүүний үнэ, цалин хөлс тогтоох арга, аргачлал
- Мэдээллийн нууц

Байгууллага өөрсдийн нууцын тухай журмыг тогтоон мөрдөж хамгаална. Мөн дараах байдлаар байгууллагын нууцаа хамгаалах зохицуулалт хийдэг. Үүнд:

- Нууцад тооцогдох мэдээллүүдийг зэрэглэх
- Мэдээлэл авч ашиглах ажилтнуудыг тогтоох
- Хөдөлмөрийн гэрээнд нууцын тухай заалт оруулах

Нууцыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэсэн тоног төхөөрөмж, компьютер хэрэгслэлийг кодлох зэрэг олон аргуудыг хэрэглэдэг. Хуулийн этгээд, аль нэг байгууллага нь иргэдээс ямар нэг мэдээлэл нууцлах, жагсаалт гаргах ёсгүй бөгөөд үүнийг зөвхөн хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

Хэрэгт хяналт тавьж буй прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг нийтэд мэдээлэх тухай зөвшөөрлийг албан бичгээр өгнө. Зөвшөөрөлд эрүүгийн хэргийн талаар ямар зорилгоор, ямар хэмжээнд нийтэд мэдээлэхийг нэг бүрчлэн тодорхой тусгаж өгнө.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно. Хэрэгт хяналт тавьж буй прокурор хүсэлтийг хүлээн авмагц эрүүгийн хэргийн материалтай танилцан нотлох баримтанд дүгнэлт хийж, эргэлзээгүй нотлогдсон, хэргийг цаашид шалгаж шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянаж, дээд шатны прокурорт танилцуулан хүсэлтийг хангах эсэхийг шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно”⁶² гэсэн заалт нь өнөөгийн байдлаар эрүүгийн хэргийн мэдээ, баримтыг хамгаалах гол эрх зүйн зохицуулалтын үүрэг гүйцэтгэж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нь прокуророос хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хэргийн дугаар авахаас эхлээд хяналт, шат дамжлага ихтэй, цаг хугацаа шаардсан нууцлал алдагдах эрсдэлтэй, мөрдөн шалгах эрх бүхий

⁶² Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг бүрэн гүйцэд ойлгож үнэлэж дүгнэх боломжгүй төвөгтэй байдал практикт бий болж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг зөвхөн тухайн хэрэгт мөрдөн байцаалт явуулж буй мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтан, хэрэгт хяналт тавьж буй прокурор харьцах бөгөөд эрүүгийн хэргийн талаархи нууцлалыг чанд хадгалах үүрэгтэй байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад цугларсан нотлох баримтууд зөвхөн гарсан хэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгддэг тул нийтэд мэдээлэх шаардлагагүй байхад хэргийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тараах явдлыг гаргуулахгүй, төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой материалыг задруулахгүй байх үүргийг мөрдөгч, хэрэгт хяналт тавьж буй прокурор хариуцана. ЭХХШ болон Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар эрүүгийн хэргийн материалыг зөвхөн прокурорын зөвшөөрлөөр нийтэд мэдээлнэ .

Мөрдөгч төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахгүй, гэмт хэрэг үйлдсэн арга хэрэгслийг сурталчилсан шинжгүй, бусдын нэр хүндийг гутаах зорилгогүй, гэм буруутай гэж шууд буруутгаагүй мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдсэн эсэхэд прокурор хяналт тавина. Эрүүгийн хэргийн дараахь материалыг нийтэд мэдээлэхийг хориглодог. Үүнд:

- Хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай гэж олон нийтэд мэдээлэх;
- Хүчирхийлэл, аллага, садар самууны холбогдолтой мэдээлэл;
- Гэмт хэрэг үйлдсэн арга хэрэгслийг нарийвчлан заасан мэдээлэл;
- Төр, байгууллага, хувь хүний нууц, нэр төр, алдар хүндтэй холбоотой хувийн мэдээлэл;
- Гэрч, хохирогчийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх эд хөрөнгө, харилцах утасны дугаар, тээврийн хэрэгслийн улсын дугаар;
- Мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой мэдээлэл;
- Хамтран ажиллах этгээдтэй холбоотой мэдээлэл;
- Хэргийг илрүүлэх, нотлох баримт цуглуулах ажиллагааны арга хэлбэртэй холбоотой мэдээлэл;
- Бүрэн шалгагдаж нотлогдоогүй, эргэлзээтэй хэрэг, нотлох баримтын талаар;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл;
- Өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох гэмт хэргийн талаархи мэдээлэл;
- Насанд хүрээгүй хүн хохирсон гэмт хэргийн талаархи мэдээлэл.

Энэ зүйлд заасан зохицуулалт нь хүсэлт, гомдлыг шалгасан материал, хэрэг, материалын хуулбар, хяналтын хавтас, хэргийн түүвэр, прокурорын даалгаварт нэгэн адил хамаарна. Прокурорын байгууллагын тухай хуулийн 17.1.3-т “албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах”⁶³ үүргийг чанд сахихаар хуульчилан баталж өгсөн. Одоогоор эрүүгийн хэргийн архивт байгаа материалтай танилцах журам үйлчилж байна. Үүнээс үзэхэд шүүхийн шийдвэр, таслан шийдвэрлэх тогтоол /шийтгэх тогтоол/, мөрдөн байцаалтаас хэрэгсэхгүй болгосон тогтоол, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол, магадлал, захирамжийг хуулбарлан авч болохоор байна.

⁶³ Төрийн мэдээлэл. 2017. №24. Прокурорын тухай хууль

Хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан, алба хаагчийн албаны нууцлал, сонор сэрэмж алба хаагчдын сахилга ёс зүйд тавих удирдах албан тушаалтны дотоодын хяналт шалгалт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо дутагдалтай байдлаас шалтгаалан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал алдагдаж хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгахад бэрхшээл учруулж байна. Тухайлбал, эрүүгийн хэргийн материалыг үндсэн эх сурвалжтай хэвлэл мэдээлэл, цахим орчинд зарим мөрдөн шалгах тодорхой ажиллагаатай холбоотой нотлох баримт, мэдээ, материал, тавигдах гэх мэт.

Хэргийн материалыг нийтэд мэдээлэх гэдгийг хэргийн материалыг зөвхөн прокурорын зөвшөөрөлтэйгөөр нийтэд мэдээлнэ гэж ойлгогддог боловч хэвлэл мэдээлэлийн байгууллага, сэтгүүлчид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг хууль зүйн үндэслэлгүйгээр шаардах, улмаар мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулж хараат бус байдалд нь сөргөөр нөлөөлж болохыг анхааран үзэх шаардлага тулгарч байна.

Мөрдөн шалгах байгууллагад шалгагдаж байгаа эрүүгийн хэргийн талаар хууль сахиулах байгууллагын нэр хүндэд тухайн хэрэгтэй нь холбогдуулан халдаж, илт үндэслэлгүй мэдээ баримт тарааж, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд саад үйл ажиллагаа идэвхтэй явж байгааг мөн анхааран үзэх шаардлага тулгараад байна. Иймд эдгээр тохиолдолд хууль зүйн хүрээнд хэрхэх вэ гэдэг асуудал зүй ёсоор тавигдана.

Үүнийг Эрүү, Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай, болон Байгууллагын нууцын тухай хуулиар зохицуулж, мэдээллийг тараасан хэвлэл мэдээлэлийн байгууллага, сэтгүүлч, цахим орчинд нийтэлсэн нийтлэлч байсан анхааран үзэж эрх зүйн зохицуулалтыг сайжрангуй болгох хэрэгтэй юм.

Дээр дурдсан хувь хүний болон байгууллагын нууцын зарим асуудал нь ЭХХШ ажиллагааны хүрээнд хамгаалагдаж байгаа тохиолдолд “ЭХХШ ажиллагааны нууцлалбал зохих мэдээ, баримт, сэлт” хэмээн үзэж болох юм гэсэн дүгнэлтийг судлаачаас хийж байна. Тэгвэл эсрэгээр мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд хохирогчийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалан оролцож байгаа сурган хүмүүжүүлэгч, сургуулийн нийгмийн ажилтан, өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нь хуулиар эрх, ашиг сонирхолоо хамгаалуулж байгаа хүн, хуулийн этгээдийн нууцыг тарааснаас болж сэтгэл зүйн сөрөг үр дагаварыг амсаж, гэрч, хохирогчийн аюулгүй байдалд нөлөөлж, ахин гэмт хэргийн хохирогч болсон жишээ баримт нэг бус байна.

Дүгнэлт. Өнөөдөр мөрдөн шалгаж дууссан эрүүгийн хэргийн материал, мэдээ баримтыг хэрхэн нууцлах, ил болгох вэ гэдэг асуудал тулгарч байна.

ЭХХШТХ-иар прокурор, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын нууцлалыг задруулан мэдээлсэн тохиолдолд хэрхэх шийдвэрлэх тухай эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй байна. Иймд прокурор, мөрдөн шалгах ажиллагааны талаархи баримт мэдээллийг задруулж мөрдөн шапгах ажиллагаанд ноцтой саад, хохирол учруулсан бол хэрхэх талаар нарийвчлан зохицуулалт оруулах шаардлагатай юм.

Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан мэдээллээс бусад тухайн хүн, хуулийн этгээдийн ЭХХШ ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээлэл мэдээлэл нийтлэх, цахим орчинд байршуулах талаар хэвлэл мэдээлэлийн байгууллага, сэтгүүлчийн хүсэлтийг эс зөвшөөрсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлтэй ч гэсэн мөрдөгч тухайн мэдээллийг нийтэд мэдээлэх эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Мөн түүнчлэн ЭХХШ хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаар хэвлэл мэдээлэлийн байгууллага, сэтгүүлч мөрдөгчөөс ямар нэгэн мэдээлэл хүсэхэд тэрхүү

мэдээллийн зөвшөөрлийг прокуророос хэн нь яаж, ямар хугацааны дотор, хэрхэн авах процедур дутагдалтай сайжруулах, зохицуулах шаардлагатай юм. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч мөрдөгчийн үйл ажиллагаанд саад учруулсан эсхүл хүнд суртал, үл ойлголцол, сэтгүүлчийн хууль тогтоомжоор олгогдсон мэдээлэл авах, хайх эрхийг хязгаарласан гэсэн нийгэмд сөрөг мэдээлэл түгээх сөрөг үр дагаврыг бий үүсгэдгийг дурьдаж болох юм.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалтай холбоотой ЭХХШХ-ийн түүвэр ишлэл

1	3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах	1.Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай, өсвөр насны яллагдагч, арван найман насанд хүрээгүй хохирогчтой холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн хэлэлцүүлэг, бүх шатны шүүх хуралдааныг нээлттэй явуулна.
2	5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг	2.9.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;
3	7.6 дугаар зүйл.Өмгөөлөгчтэй харилцах	2.Өмгөөлөгч цагдан хоригдсон яллагдагчтай ганцаарчлан уулзах өрөө нь харилцааны нууцлалыг хангасан байна.
4	8.3 дугаар зүйл.Мэдээллээр хангуулах	3.Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй. 4.Прокурор, мөрдөгч нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад мэдээллийг нууцалж болно.
5	9.3 дугаар зүйл.Мэргэжилтэний эрх	3.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх
6	9.7 дугаар зүйл.Хөндлөнгийн гэрч	4.Хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн гэрчийн мэдүүлэг өгөхөөр шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, мөрдөн шалгах ажиллагааны журам сахих, нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.
7	13.1 дүгээр зүйл.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл	1.3.мэдээллийн нууцлалыг хангах; 2.1.нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах; 2.2.нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаархи мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох; 9.Гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор мөрдөгч өөрийн санаачилгаар, эсхүл гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.
8	13.6 дугаар зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоох шүүхийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	2.Хаалттай явуулсан шүүхийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, бичлэг, тэдгээртэй холбоотой материалыг нууцалж, хавтаст хэргээс тусад нь битүүмжлэн хадгална.
9	16.3 дугаар зүйл.Мэдүүлэг	8.1.нэрийг нь нууцалсан гэрчийн мэдүүлэг;
10	23.2 дугаар зүйл.Хүний биед үзлэг хийх	4.Нүцгэлж хийх үзлэгийг хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, хувь хүний нууцыг хамгаалах шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд явуулна.
11	23.3 дугаар зүйл.Хэргийн газрын үзлэг	3.11.төр, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл алдагдах, эд хөрөнгө устгах, үрэгдэхээс хамгаалах.
12	24.4 дүгээр зүйл.Эд мөрийн баримт хураан авах	2.Төрийн нууц агуулсан эд мөрийн баримтыг зохих байгууллагын удирдлагад мэдэгдсэний үндсэн дээр хураан авна.

13	24.5 дугаар зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах	1.Мөрдөгч төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан, хүн нь прокурорын шийдвэрт заасан хугацаанд мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, нууцлалыг хадгална.
14	32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах	12.Энэ хуулийн 16.8 дугаар зүйлд заасан баримт бичиг, төрийн нууцад хамаарагдах баримт бичигт энэ зүйлийн 4 дэх хэсэг хамаарахгүй.
15	32.6 дугаар зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын тогтоолыг танилцуулах	3.Төрийн нууцтай холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид тогтоолыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гардуулахгүйгээр танилцуулж болно.
16	34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах	2.1.төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх
17	35.18 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах	2.Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчоос шүүх хуралдаанд мэдүүлэг авахын өмнө тухайн гэрч, хохирогчийг ил болгоно.

1949, 1963, 2002, 2017 онд батлагдсан хуулиудад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлалын эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэлийн харьцуулалт:

1949 оны ЭБШхууль	1963 оны ЭБШхууль	2002 оны ЭБШхууль	2017 оны ЭХХШТХууль
Нэг зуун хорин ес. Урьдчилсан Мөрдөнбайцаалтаар олж илрүүлсэн мэдээ баримтуудыг гагцхүү мөрдөн байцаагчийн үзэж буйн хэмжээгээр олон нийтэд сонсгох болно. Урьдчилсан мөрдөн байцаалтаар олсон мэдээ баримтуудыг мөрдөн байцаагчийн зөвшөөрөлгүйгээр олонд сонсговоос хуулиар цээрлүүлнэ.	133-р зүйл. Хэрэг бүртгэлт, урьдчилсан мөрдөн байцаалтын материалыг задруулж болохгүй Хэрэг бүртгэлийн ба урьдчилсан мөрдөн байцаалтын материалыг гагцхүү хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын зөвшөөрснөөр тэдний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно. Шаардлагатай үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаалт хэрэг бүртгэлт урьдчилсан мөрдөн байцаалтын материалыг залруулж болохгүй тухай гэрч, хохирогч, иргэний нэхэжлэгч, иргэний хариуцагч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хөндлөнгийн гэрч, мөрдөн байцаалт явуулахад байлцсан бусад хүмүүст урьдчилан мэдэгдэж хэрэв үүнийг зөрчсөн байвал БНМАУ-ын эрүүгийн хуулийн	189 дүгээр зүйл. Хэрэг бүртгэлт,мөрдөн байцаалтын материалыг задруулахыг хориглох 189.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно. 189.2. Шаардлагатай үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг задруулж болохгүй тухай гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч,иргэний хариуцагч, өмгөөлөгч, шинжээч,орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч,мөрдөн байцаалт явуулахад байлцсан бусад хүмүүст урьдчилан мэдэгдэж, хэрэв үүнийг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэхийг	29.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал 1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана. 2.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авна. 3.Мөрдөгч төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна. 4.Мөрдөн шалгах ажиллагааны явцад төрийн нууцтай холбоотой асуудал гарвал мөрдөгч эрх бүхий байгууллагын удирдлагад мэдэгдэж, нууц хариуцсан албан тушаалтныг байлцуулна. 5.Хэрэг бүртгэлт, мөрдөн

	151 –р зүйлд зааснаар хариуцлага хүлээлгэхийн сануулж гарын үсэг авна.	сануулж тэднээс гарын үсэг авна.	байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно.
--	--	----------------------------------	--

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж

1. Эрүүгийн хууль, 2015 он
2. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
3. Прокурорын байгууллагын тухай хууль, 2017 он
4. Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он
5. Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он
6. Төрийн нууцын тухай хууль, 2016 он

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

1. “Монгол Улсын хуучин ба шинэ ЭБШХуулиудын харьцуулсан судалгаа”. УБ., 2002.
2. Б.Лхагварагчаа, П.Эрдэнэбаатар, А.Дэлгэрбаяр, Эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий тусгай анги. УБ., 2021.

Гурав. Цахим эх сурвалж

1. <http://time.mn/2a5.html>
2. <https://advocate.mn/news/119/single/110>
3. Гэмт хэргийн статистик 2021 мэдээ
4. Мөрдөн шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын аргачилсан заавар” УБ., 2021
5. "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын төрөлжсөн архивын ажлын заавар, "Эрүүгийн хэргийн архивын журам Улсын Ерөнхий прокурорын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 33 тоот тушаалын 1-р хавсралт

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДААС ҮЙЛДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

ЦЕГ-ын Тусгай ажиллагааны газрын ажилтан,
цагдаагийн ахлах дэслэгч Ж.Баттулга

Товч агуулга: Цагдаагийн алба хаагчаас бусдын эрүүл мэндэд хохирол учруулах үйлдлийн өнөөгийн байдал, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг, ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхойлсон.

Түлхүүр үг: Ёс зүй, шалтган нөхцөл, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх

Үндсэн хэсэг. Цагдаагийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудал нь Цагдаагийн байгууллагын нэн тэргүүний зорилт болж байна.

Сүүлийн 6 жилийн байдлаар цагдаагийн албан хаагч үйлдсэн 592 гэмт хэрэгт Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэсээс хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ. Үүнээс хөнгөн гэмт хэрэг 271, хүндэвтэр гэмт хэрэг 284 /2017 оноос урагш/, хүнд гэмт хэрэг 14, онц хүнд гэмт хэрэг 4 /2017 оноос урагш/ бүртгэгдсэн байна.

2015 онд	138
2016 онд	134
2017 онд	69
2018 онд	48
2019 онд	79
2020 онд	48
Нийт онд	592

2017 онд Цагдаагийн албаны хууль шинэчлэн батлагдаж түүнд холбогдох олон журам, заавар шинэчлэгдэн Цагдаагийн байгууллагын сахилга, ёс зүйг өндөрүүлэх аян зохион байгуулсаны үр дүнд цагдаагийн албан хаагчаас үйлдсэн гэмт хэргийн гаралт буурах төлөвтэй байсан. Харин 2019 онд 31 гэмт хэргээр буюу 39%-р өссөн байна. 2019 онд цагдаагийн албанд шинээр 750 орчим албан хаагч томилогдсонтой холбоотой гэмт хэргийн гаралт өссөн байх магадлалтай.

Нийт шалгагдсан гэмт хэргийн төрөл

д/д	Он	Хүний амьд явах эрхийн болон Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг ЭХТА-10, 11-р бүлэг	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ЭХТА-17-р бүлэг	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг ЭХТА-20-р бүлэг	Авлигын гэмт хэрэг ЭХТА-22-р бүлэг	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг ЭХТА-21-р бүлэг	Бусад
1	2015	55	6	4	6	15	52
2	2016	65	20	8	5	7	29

3	2017	35	10	5		5	14
4	2018	25	4	4	-	3	12
5	2019	48	7	-	-	12	12
6	2020	24	8	-	-	7	9
	Нийт	287	57	26	16	56	150

Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж байгаа гэмт хэргийн төрлөөс Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг хамгийн их буюу 287 гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Энэ нь ихэвчлэн эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэж байх үедээ иргэдийн эрүүл мэндэд хөнгөн, хүнд, хүндэвтэр хохирол учруулах тохиолдол их байна.

Мөн энэ гэмт хэргийн гаралтад нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлд ихэвчлэн цагдаагийн албан хаагчийн ёс зүйн алдаа буюу иргэдтэй зүй бус харилцсанаас үүдэлтэй байна. Тиймээс цагдан сэргийлэх шинэ байгууллага гэмт хэрэг зөрчилтэй тэмцэхдээ ганцаараа биш төр засаг олон нийтийн бүх байгууллага ялангуяа хууль хамгаалах байгууллагууд ,иргэд хөдөлмөрийн хамт олонтой нягт хамтран ажиллаж энэ ажлыг бүх нийтээрэй үйлс болгоход ажлаа чиглүүлж иржээ гэж бичсэн байна.

Цагдаагийн алба хаагчдаас үйлдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тун бага ярьж байсан нь саяхан билээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоо чухал үүрэгтэй. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өрнүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг.

Цагдаагийн алба хаагчдаас үйлдэж буй гэмт хэрэг нь өөрийн онцлогтой тул шалгаж тогтооход төвөгтэй. Хуулийн хэм хэмжээгээр халхавчилсан, далд, эрх мэдэл, албан тушаалаараа далайлгасан, нарийн зохион байгуулсан хэлбэртэй байдаг. Иймээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөтэй, хөтөлбөртэй, нарийн зохион байгуулалттай, үндэслэлтэй хийх учиртай. Албаны сургалт, соён гэгээрүүлэх, мэргэшүүлэх, ур чадвар эзэмшүүлэх, хандлагыг өөрчлөх ажлыг үр дүнтэй зохион байгуулах ёстой.

Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой. Учир нь цагдаагийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн дийлэнх хувь нь тэдний мэдээлэлээр илэрч байна.

Тэгэхлээр энэ талын хяналтыг илүү бэхжүүлэх шаардлагатайг харуулж байна. Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэс нь Цагдаагийн алба хаагчдын боловсрол, мэргэжил, албаны соёл, ур чадварыг дээшлүүлэх тэдний сахилга, ёс зүйг төлөвшүүлэх явдал юм.

Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцлийг цаг алдалгүй арилгахад чиглэгдсэн эрх зүй, ёс суртахуун хүмүүжлийн болон зохион байгуулалттай арга хэмжээнд түлхүү анхаарах ёстой.

Энэ төрлийн гэмт хэргийн илэрүүлэлтийг сайжруулах, иргэдээс мэдээ, мэдээлэл сайн авах, гэмт хэрэг хийхээр бэлтгэж байгааг урьдан мэдэж таслан зогсоох, гэмт хэрэг хийж болзошгүй албан хаагчдийн санаа бодлыг урьдчилан мэдэх, уг санаа бодлоос татгалзуулах, дотоодын хяналтыг өндөржүүлэх шаардлагатай байна.

Мөн цагдаагийн албан хаагчид гэмт хэрэг үйлдэж буй нэг нөхцөл архидаг согтуурах явдал байна. Төрийн бүх шатны байгууллагад архидаг согтуурах явдлыг таслан зогсоох, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар гарсан Засгийн газрын тогтоолыг биелүүлж ажилласнаар ахиц гарч байна.

Цагдаагийн албан хаагчдаас согтуугаар гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байна. 2008 онд Цагдаагийн ерөнхий газраас “Цагдаа, дотоод цэргийн алба хаагчдын харилцааны соёл, сахилга, ёс зүйг дээшлүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлжсэн. Согтууруулах ундаа хэрэглэх явдалтай эвлэрхгүй байх, ажлаас халах, хамт олонд мэдээлэх, согтууруулах ундааны хор хөнөөлийн талаар, сургалт зохион байгуулах, тайлбарлан таниулах шаардлагатай.

Цагдаагийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн гаралтыг багасгах зайлшгүй шаардлагатай авах арга хэмжээний нэг нь цагдаагийн байгууллага, албан хаагчдын дотоод аюулгүй байдлыг хангах асуудал юм. Аюулгүй байдал, хамгаалалтын үйл явцаас хожимдож, хоцрох, анхаарал болгоомжлол, албаны сонор сэрэмж алдах нь аюул заналд өртөх эрсдэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх үр дагавар, шалтгаан нь болдогийг анхаарах хэрэгтэй.

Тиймээс аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн цогц арга хэмжээнүүдийг байнга цаг үе, нөхцөл байдалтайгаа нийцүүлэн мэдэрч шинэчилж, сайжруулж гадаад, дотоод орчинд шинээр гарч буй аюул занал, эрсдэлд зохих хариу үйлдэл үзүүлж чадахуйц түвшинд авч үзэж байх шаардлагатай болж байна.

Аюулгүй байдлыг бүрдүүлэгч олон талт жижиг бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн зохион байгуулж, нэг тогтолцоонд оруулснаар сая л аюулгүй байдлыг зохих түвшинд нь хангах бололцоо бий болдгийг санах хэрэгтэй. Үүнээс үзэхэд байгууллага \объект\ -ын болон алба хаагчийн аюулгүй байдлыг бүрдүүлэгч гол хүчин зүйл нь чадавхи, боломж юм.

Байгууллага \объект\ алба хаагчийн аюулгүй байдлыг хангах нь цагдаагийн байгууллага, алба хаагч бүрийн хариуцлага байх бөгөөд хувь хүний аюулгүй байдлын 80 хувь нь тухайн албан албан хаагчаас өөрөөс нь шалтгаалдаг. Хувь хүн өөрийн аюулгүй байдалдаа анхаарал хандуулж эхлэснээр өөрийн орчин тойроныхоо аюулгүй байдлыг өөрийн эрхгүй хангаж эхэлдэг гэдгийг бас санах хэрэгтэй. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа мэргэжлийн алдаанд орох болон амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулах гэмт хэрэг сүүлийн 5 жилд 252 бүртгэгдсэн ба эдгээр тохиолдлуудын дийлэнх нь согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг түр саатуулах, эрүүлжүүлэх явц үйлдэгдсэн байна.

Энэ нь нэг талаасаа цагдаагийн байгууллагын зүгээс алба хаагч нарын эрх зүйн талаас нь ажиллах баталгааг бүрэн дүүрэн хангаж өгөөгүйтэй холбоотой ч нөгөө талаас алба хаагч нарын дунд иргэдтэй харьцах харьцааны соёл дутмаг, өдөр тутмынхаа үйл ажиллагаагаа зохицуулсан хууль эрх зүйн актуудыг сайтар уншиж судалдаггүй, тэдгээрийн талаар ерөнхий ойлголттой байх, энэхүү байдлаасаа шалтгаалж согтуу хүмүүстэй яг тэр байдлаар харьцаснаас үүдэн өөрсдөө албан үүргээ гүйцэтгэж яваад ямар нэг байдлаар хохирч, аюулгүй байдал нь алдагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Шинээр томилогдсон албан хаагчдад халамжлан хүмүүжүүлэгч буюу дадлага туршлагатай ажилтнуудад хариуцуулан өгч тодорхой хугацаагаар дагалдуулан сургах ажлыг хэвшүүлэх

Албан хаагчдын дунд соён гэгээрүүлэх ажлыг цагдаагийн албан хаагчдын дунд зохиох мэдээлэл сурталчилгааны ажлын онцлог нь тэдний оюун санаа, сэтгэхүйг хөгжүүлэх, хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх үзэл, соёл,

сахилга ёс зүйг төлөвшүүлэх нөхцлийг бүрдүүлж, албаны онцлогоос үүссэн сөрөг нөлөө, сэтгэл зүйн алжаал, ажил амьдралын бухимдал, стрессийг тайлах, албаны онцлог, түүхэн уламжлал, зан заншлаа сурталчлах, цагдаагийн алба хаагчдын сахилга ёс зүй, ялангуяа харьцааны соёл, гоо зүйн хүмүүжил, шударга ёс энэрэнгүй үзлийг төлөвнгүүлэх гэх зэрэг ажлуудыг чанартай хийх нь алба хаагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам мөн.

Ялангуяа цагдаагийн албан хаагчдын соёл хүмүүжлийн ажлаас хоцорч байгаа зүйл бол алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх ажил туйлын хангалтгүй бөгөөд хамт олонч сэтгэлгээ, хандлагыг хөгжүүлэх нь албан хаагчийн ёс зүй, төлөвшилд чухал нөлөө үзүүлдэг.

Тухайлбал цагдаагийн мэргэжлийн болон албаны талаар ярилцлага, хэлэлцүүлэг зохиох, нэг бүрчилсэн сургалт зохиох, харилцан ярилцах, сонсох, нэг бүрчлэн үүрэг даалгавар өгөх, нэг бүрчлэн хяналт тавих арга, ар гэрийхний дунд зохиох зэрэг шинэлэг арга барилыг сонгож уйгагүй ажиллах нь алба хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх аргын нэг хэлбэр болно. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд зааснаар урьдчилан сэргийлэх ажлыг ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх гэж ангилжээ.

Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж байгаа гэмт хэргийн гаралтыг бууруулахад, дээрх хуулийн зохицуулалтад нийцүүлэн урьдчилан сэргийлэх дараахь арга зам байгааг танилцуулж байна. Үүнд:

Нэг.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ерөнхий чиглэлийн хүрээнд:

1. Цагдаагийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах талаар нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх. Цагдаагийн албан хаагчийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх талаар төрөөс орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх шаардлага байна.Тухайлбал нийслэлд хямд үнэтэй орон сууцаар хангах бодлого байрьж байгаа ч тэр бүр албан хаагчдын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хэмжээнд хүрэхгүй байна. Орлогын хэмжээ хүрэхгүй, 30%-ыг өгч чадахгүй албан хаагч цөөнгүй байна.

Орон нутагт ая тухтай амьдрах боломжтой, амьдралын наад захын хэрэгцээ хангахуйц байр, албан тасалгаа дутагдалтай. Кобон нь хуучирсан, засвар үйлчилгээ хийддэггүй, төсөв байхгүй, хүн амвдрах нөхцөлгүй байдалд байна. Цагдаагийн албан хаагчдад чиглэсэн хөнгөлттэй зээл, хямд баталгаатай байр, орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага байна. Өнөөдрийн байдлаар төрийн тусгай байгууллагаас хамгийн бага цалин авч байгаа нь цагдаагийн байгууллага байна. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бүх хууль сахиулах байгууллага цалингаа нэмсэн. Тийм учраас цагдаагийн байгууллагын ажлын ачаалал, нөхцөл, онцлогт тохирсон цалингын тогтолцоог яаралтай боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Цагдаагийн албан хаагчийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөт ажил зохион байгуулж, шаардлагатай төсөв, хөрөнгийг бүрдүүлэх, тэдэнд хууль, тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг сурталчлах,

3. Цагдаагийн байгууллагын бүх газар, алба, хэлтэс, тасгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, нэгдсэн сүлжээнд холбох, камержуулан нэгдсэн сүлжээнд холуож хянах, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх хэрэгцээ, шаардлага үүсч байна.

Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тусгай чиглэлийн хүрээнд

1. Цагдаагийн албан хаагч оролцсон гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийдэг бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсоох, ялангуяа албаны эрх мэдлээ ашиглан бусдад гэмт хэрэг үйлдэх боломж олгосон үйлдлийг шуурхай илрүүлэх, ашиг орлого, мөнгөний урсгалыг зогсоох

2. Цагдаагийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэргийн талаар мэдээлсэн, илрүүлэхэд хамтран ажилласан иргэдийн амь, нас, эрүүл мэнд, байгууллагын аюулгүй байдлыг хамгаалж ажиллах, эрсдэлд орохоос сэргийлэх

3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тухайн гэмт хэрэг үйлдсэн албан хаагчаас нэн яаралтай гаргуулан барагдуулах

4. Гэмт хэрэг ихээр үйлдэгддэг БЗД-ийн Цагдаагийн 2-р хэлтэс, Багануур, Дорнод, Архангай, СХД-ийн Цагдаагийн 2, 3-р хэлтсийн албан хаагчдад чиглэсэн гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд

1. Цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаа нь хэнд ч ойлгомжтой шуурхай, тасралтгүй байж, хуулиа дээдлэн, шударга ёс, тэгш байдлыг ханган, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, ажил хэрэгч, соёлч, цагдаагийн албан хаагчийн нэр төр, алдар хүндийг ямагт өргөж, өөрийгөө хөгжүүлэн, мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж байх

2. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хэм хэмжээний эрх зүйн акт, дээд шатны байгууллага, албанн тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг ёсчлон биелүүлж, захирах, захирагдах ёсны зарчмыг ямагт баримтлан, үйл ажиллагаандаа хэвшүүлэх

3. Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албанн тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй, хүнлэг байхыг байнга сануулах

4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдын эрхэнд хууль бусаар халдах, чирэгдүүлэх, дарамтлах, хүнд суртал гаргасан албан хаагчид хариуцлага хүлээлгэх

5. Албан тушаал, хуулиар олгогдсон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглахгүй байх, албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан аливаа этгээдэд давуу байдал бий болгох, үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж авах, үйлчилгээ, зээл авах, ийнхүү авахаар шахаж шаардах, ятгах, бусдад зуучлах, хуульд харш болзол тавих, далайлган сүрдүүлэх, бусдын өмч хөрөнгийг хувийн болон албан ажилд ашиглахгүй байхаас байнга зайлхийж байх талаар сануулах, энэ чиглэлийн сургалтыг зохион байгуулах

6. Албан хаагчийн шалгаж байгаа мэдээ, мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлт нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх ажиллагааг хэвшүүлэх

7. Цагдаагийн байгууллагын нэр төр, алдар хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл, эс үйлдэл гаргасан албан хаагчид зохих хариуцлага хүлээлгэж хамт олонд мэдээлэх

8. Өөрийн мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшингээ дээшлүүлэх нь насан туршийн үйл явц гэж ухамсарлан ойлгож, бүхий л боломж, бололцоог ашиглан өөрийгөө хөгжүүлж, өөрийн алдаа, дутагдлыг арилгахыг эрмэлзэж байгаа албан хаагчыг дээд шатны удирдах албан тушаалтан дэмжлэг үзүүлж ажиллах, урамшуулах, хамт олонд үлгэр дуурайл болохуйц үйлдлийг алдаршуулж нийт албан хаагчдад таниулах.

Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд

1. Цагдаагийн албан хаагч нь бусдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчин, хууль ёсны шаардлага тавих, холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай мэдээлэх

2. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг сахин мөрдөж, байгууллага, албаны хаагчийн нэр хүндийг ямагт хүндэтгэж явах талаар тайлбарлан таниулах

3. Ёс зүйн хувьд бусдад үлгэр дуурайлал үзүүлсэн, иргэд, байгууллагын талархал хүлээсэн албан хаагчийг хамт олны өмнө сайшааж хувийн хэрэгт тэмдэглэх, цалинг үр дүнгээр нэмэх, боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах эрх олгох, цалинтай амралт, сувилалд хамруулах, цагдаагийн байгууллагын болон салбарын шагналд шагнуулахаар тодорхойлох, албанн тушаал дэвшүүлэх саналыг эрх бүхий албан тушаалтанд уламжлах

4. Өөрийн болон албаны нэр төрийг ариун байлгаагүй, иргэдтэй соёлтой, хүнлэг, хүлээцтэй харьцаагүй, үл тоосон, шаардлагагүй баримт бичиг нэхэж, чирэгдүүлсэн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, ялгаварлан гадуурхаж, эрхшээлдээ байлгасан, басамжлан доромжилсон, сүрдүүлсэн бол албанаас чөлөөлж хяналт шалгалтыг хэрэгжүүлэн үр дүнг нийт албан хаагч болон олон нийтэд мэдээлэх

5. Цагдаагийн албан хаагч нь ажлын байранд мөрийтэй, бооцоотой тоглоом, иргэний хувьд хуулиар хориглосон тоглоом тоглож, зохион байгуулахад оролцсон үйлдлийг олон нийтэд мэдээлж, зохих хариуцлага хүлээлгэх ёстой.

Тав. Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хүрээнд

1. Цагдаагийн албан хаагчаас үйлдсэн гэмт хэрэг бүрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, бодитой, шуурхай, тал бүрээс нь үнэлж хянан шийдвэрлэх

2. Цагдаагийн албан хаагчаас үйлдэж бүртгэгдсэн гэмт хэрэг бүрт зохих журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, танил тал ашиглан хэргийг хэрэгсэхгүй болгох, ял завших явдлыг гаргуулахгүй байх

3. Цагдаагийн албан хаагчын үйлдсэн гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, байгууллагын зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах, олон нийтэд мэдээлэх, сурталчлах

4. Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх эрх бүхий албан хаагч хуульд заасан тусгай чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломж, баталгааг бий болгох

5. Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх эрх бүхий албан хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх шаардлагатай.

Зургаа. Ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах хүрээнд

1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, хамтран ажиллаж байгаа албан хаагчтай адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, тэдний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, шударгаар ажиллаж, амьдрах

2. Бусад байгууллага, хамтран ажиллаж байгаа албан хаагчийн албанны ажилд хүндэтгэлтэй хандаж, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхгүй, бусдад зуучлахгүй байх, харьяаллын бус хэрэг маргаанд оролцохгүй байх

3. Авлига, хээл хахууль авах, өгөх, зуучлахгүй байх
4. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж авсан мэдээ, мэдээллийг цагдаагийн байгууллага, албан хаагчийн нэр төрд харшилж болох болон өөрийн санхүү, эдийн засгийн аливаа хэлцэл, хөрөнгө оруулалт, эдийн засгийн бусад ашиг сонирхлоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх, зуучлахгүй байх
5. Байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгслийг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх
6. Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх, энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж, оролцохгүй байх
7. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, буруу мэдээллээр хангах замаар удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх
8. Ажлын байранд, ажлын цагаар, албан үүрэг гүйцэтгэж явахдаа болон цагдаагийн дүрэмт хувцастай согтууруулах ундаа хэрэглэх, хуулиар хориглосон газарт тамхи татахгүй байх
9. Олон нийтийн газар, авто зам, гудамж талбайд бие засах, эсхүл нус цэр, шүлс, тамхины иш, хог хаяхгүй байх
10. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх
11. Шалгаж байгаа өргөдөл, гомдол, хэрэг, маргааны оролцогчидтой хувийн харьцаанд орохгүй байх
12. Гэр бүл, үр хүүхдэдээ хайр, халамжтай байж, нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх
13. Олон нийтийн цахим сүлжээ, мэдээллийн сувгуудад зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албанны мэдээ, мэдээлэл, цагдаагийн дүрэмт хувцастай зураг, санал, сэтгэгдэл оруулахгүй, ажлын цагаар хувийн асуудлаар цахим сүлжээнд орохгүй байх
14. Цагдаагийн дүрэмт хувцас, албаны үнэмлэх, тэмдэг, тусгай болон техник хэрэгслийг бусдад дамжуулах, хэрэглүүлэх, бусдад барьцаа болгон үлдээхгүй байх
15. Иргэдтэй маргалдах, хэл амаар доромжлох, зохисгүй үг хэллэг хэрэглэх, шивнэлдэх, инээлдэх, залхсан, эсвэл уцаарласан өнгөөр харьцах зэргээр зан харьцааны дутагдал гаргахыг цээрлэх
16. Цагдаагийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харьцах

Дүгнэлт. Дээрх өгүүллийн агуулгад түшиглэн дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. Албан хаагчдын дунд гэмт хэрэг үйлдэж болох талаар зан төлөв байсаар байна.
2. Цагдаагийн албанн хаагчдаас үйлдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй бүх шатанд тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч тогтвортой буурахгүй, нуугдмал гэмт хэрэг байсаар байна. Энэ төрлийн гэмт хэрэгт цагдаагийн өндөр албанн тушаалтанууд мөн оролцох боллоо. Эдгээр үйлдлүүд нь иргэдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх боллоо.
3. Цагдаагийн албан хаагчдаас нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, бусдын эд хөрөнгийг хувьдаа завших, хээл хахууль авах, зуучлах, хүчиндэх, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол санаатай учруулах зэрэг гэмт хэргүүд үйлдэж ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчиж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч ажиллах шаардлагатайг харуулж байна. Энэ төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр алба хаагчдын ажлын гүйцэтгэлийг тоон үзүүлэлтээр бус чанарын

үзүүлэлтээр дүгнэж түүнд тавих удирдлагын хяналтыг сайжруулж мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг эрс сайжруулах шаардлагатай байгааг өгүүллийн агуулгаас харж болно.

4. Цагдаагийн албан хаагчдыг байнга сургаж, бэлтгэж, мэргэшүүлж, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, түүнчлэн алба хаагч бүрийг цаг ямагт өөрийн мэдлэг, боловсролоо байнга ахиулж, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн шаардлагыг мэдэрч хөгжиж боловсорч байх үүрэгтэйг анхааруулж түүнд чиглүүлсэн соён гэгээрүүлэх ажлыг сайтар зохион байгуулж төрөл бүрийн спортын арга хэмжээ, уулзалт ярилцлага, зөвлөгөөн, эрх зүй, гадаад хэл, компьютерийн сургалт, иргэд олон нийттэй эрүүл тааламжтай харилцаа тогтоох зорилго агуулга бүхий сургалт, арга хэмжээг илүү санал, санаачлага гарган үр дүнтэй зохион явуулах ажил дутагдалтай байна.

Санал. Цагдаагийн албан хаагчдаас үйлдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг сайжруулахад дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шинээр томилогдож буй алба хаагч бүрт ажил амьдралын дадлага туршлагатай, хариуцлагатай алба хаагч нарыг дагалдуулан сургах, халамжлан хүмүүжүүлэгчээр томилж, ажилд нь сурган дадлагажуулах, хувийн байдлыг сайтар судлах, тодорхой хугацааны дараа албан тушаалд томилох

2. Цагдаагийн албан хаагч нарын хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналхийлэх, амь биед нь халдсан гэмт хэрэгт хуульд заасан хариуцлагыг оногдуулах талаар хууль сахиулах бусад байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах. Цар тахлын үед үйлдэгдсэн хууль сахиулагчдыг сэргүүцэх гэмт хэргийн шинжтэй үйлдлийг Зөрчлийн тухай хуулийн 15.2-р зүйлээр зүйлчилж шийтгэл оногдуулж байсан нь хуулийг буруу хэрэглэх, иргэдэд буруу ойлголт, төсөөлөл бий болоход нөлөөлсөн.

3. Цагдаагийн байгууллагын газар, хэлтэс, алба нэгж дээр байгаа гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, сахилгын зөрчил үйлдэж болзошгүй эрсдэл бүхий алба хаагч нарт чиглэсэн урьдчилан сэргийлэх тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн зохицуулалтад тулгуурлан хэрэгжүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ДҮР ТӨРХ СУДЛАЛЫГ АШИГЛАЖ ИРСЭН НЬ

Г.Бямбадорж

*Цагдаагийн сургуулийн Цагдаагийн
эрх зүйн тэнхимийн ахлах багш,
магистр, цагдаагийн дэд хурандаа*

Товчлол: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гэмт хэрэгтнүүдийн дүр төрх, онцлог содон шинж, тэмдэгийг гадаадын зарим улсад тухайлбал, Швейцар, Герман, Франц, АНУ, ОХУ-сад криминалистикийн дүр төрх судлалын ухааныг үүсгэн хэрхэн хөгжүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байсан талаар товч авч үзлээ.

Түлхүүр үгс: Криминалистик, тоо бүртгэл, дүр төрх, онцлог содон шинж, хэмжээ

Үндсэн хэсэг. Криминалистикийн шинжлэх ухаанд хүний дүр төрх судлал нь мэдлэгийн нэгэн тусгай салбар болж хөгсөн байна. Энэ нь хүний гадаад төрх байдал, түүний ангилал, онцлог, шинж чанарын талаар авч үздэг.

Хүний дүр төрхийг судлах, түүний шинж тэмдэгийг тодорхойлох үйл явц МЭӨ 4-р зууны үед Эртний Египтэд зугтаж гарсан хүмүүсийг хайх зорилгоор тэдний гадаад төрх, нас, өндөр, зургийн онцлог, арьсны өнгө, үс, нүд, нүүрний хэлбэр гэх мэтийг шинж тэмдэгийг ашиглан эрэн хайж байжээ.⁶⁴ Тухайлбал, түүхч И.Ф.Крыловын тэмдэглэлд МЭӨ 4-р зууны эхэн үед Аристогены залуу боол, Крисипусын хүү Александрия руу зугтав. Боолын нэрийг Херман, хоч нь Нейлос. Тэрээр Сирийн уугуул 18 настай, тэрээр дунд зэргийн өндөр, сахалгүй, шулуун хөлтэй, уруулын зүүн хэсэгт сорви, хамрын зүүн талд тууралттай, нөмрөг, арьсан хормогчтой боолгийг эрэн сурвалжилж барьсан тухай тэмдэглэсэн байна.

Түүнчлэн гадаад шинж тэмдгүүдийг тайлбарлах үйл явц үргэлжилж XVIII зууны төгсгөлд Оросын Холбооны Улсад гэмт хэрэгтнүүдийн гадаад төрх байдлын талаархи мэдээллийг бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж байсан нь 1843 онд олджээ.

Францын Эрүүгийн цагдаагийн үүсгэн байгуулагч "Сурте" цагдаагийн газарт бүртгэлтэй байсан бүх гэмт хэрэгтнүүдийн тухай мэдээллийг цуглуулж архив байгуулжээ. Уг архивт гэмт хэрэгтнүүдийн нэр, үйлдсэн гэмт хэргийн төрөл, гадаад төрхийг тодорхойлж бичжээ.

1829 онд Парис хотод Шүүгчийн дэргэд гэмт хэрэгтнүүдийг олж тогтоох зорилгоор бүртгэлийн карт хөглөж хадгалах ажлыг эхлүүлж бүртгэгдсэн гэмт хэрэгтнүүдийн нэрээр картуудыг цагаан толгойн үсгээр дараалан хэдэн арван жилийн турш байрлуулсан байв.⁶⁵

Ийм картын индексийг ашиглан цагдаагийн байгууллагаас саатуулагдсан хүний хэн болохыг тогтоох боломжтой байсан. Гэхдээ тэр нь жинхэнэ овог, нэр эсэх нь эргэлзээтэй байв. 1870-аад оны сүүлчээр хэдэн сая ийм карт цуглуулсан байсан ч шүүхийн танхимын үр ашиг тийм ч өндөр биш байв.

Гэмт хэрэгтнүүд зургийг 1840-өөд онд авч эхэлсэн бөгөөд гэрэл зургуудыг бүртгэлийн картад нэмж оруулан 1874 оны 1-р сараас эхлэн Парисын цагдаа нар гэмт хэрэгтнүүдийн гэрэл зургийн цомгуудыг цуглуулж эхлэв. Берлиний Эрүүгийн цагдаагийн

⁶⁴ Крылов И.Ф. Очерки истории криминалистики и криминалистической экспертизы. Л., 1975. С-78

⁶⁵ Торвальд Ю. Сто лет криминалистики. М., 1974. С-98

газарт 1876 онд гэмт хэрэгтнүүдийн зургийн цомгийг нэвтрүүлж, тэнд байгаа гэрэл зургуудыг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж байжээ.

Харин Америкт 1820-1850 оны хооронд хүний гадаад шинж чанараас зан авир, зан байдлын талаар дүгнэлт гаргахыг оролдсон. Хүний гаднах шинж чанаруудыг дотоод бие махбодийн шинж чанаруудтай өөрөөр хэлбэл тархины хэлбэрийг харьцуулахыг оролдсон бөгөөд энэ нь мэдэгдэхүйц дэвшил байв.⁶⁶

Дарвины онолыг суурь болгон ашигласан хүмүүсийн нэг Ломбросо юм. Тэрбээр гэмт хэрэгтнүүд нь гэмт хэрэг үйлдээгүй хүмүүс шиг хувьсан өөрчлөгдөөгүй бөгөөд гэмт хэрэг нь гэмт хэрэгтнүүд ба гэмт бус хүмүүс хоорондын биологийн ялгаанаас үүдэлтэй гэж үзэж байв.

Ломбросо нь ноцтой гэмт хэрэгтнүүд эрүүгийн шинж чанараа өвлөж, төрдөг гэж тайлбарласан. Тэд хүчтэй эрүү, том шүдтэй, дух нь томорсон, урт гартай байв. Эдгээр төрлийн гэмт хэрэгтнүүд нийт гэмт хэргийн гуравны нэг орчим хувийг эзэлж байжээ.⁶⁷

Иймд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, хорих ял шийтгэгдсэн, хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн зэрэг судалгаанд дээр дурьдсан онцлог содон шинж тэмдэг, хувийн зан төрх байдал зэргийг судалж объектын судалгаанд тусгах онол, практикийн ач холбогдолтой байна. Үүнийг хорих ял эдлээд суллагдсан хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн тоо үзүүлэлтээр тайлбарлаж болох юм.

1860 онд Лувены шоронгийн дарга Стивенс Швейцарь хоригдлуудын бие махбодийн хэсгийг хэмжиж, үр дүнг бүртгэлийн картан дээр бичиж эхлэв. Стефенсийн үйл ажиллагааг түүний гадаад үзэмжээс хамааран хүний гэмт хэргийн бүртгэл эхэлсэн гэж үзэж болно. Гэсэн хэдий ч Парисын цагдаагийн албан тушаалтан Альфонс Бертиллон үүнийг антропометрийн таних нэрээр боловсруулсан бөгөөд ийм бүртгэлд суурилсан шинжлэх ухааны аргыг Францад бодитоор хэрэгжүүлжээ. Бертлон энэ системд орж, антропологийн судалгааны арга зүйг антропологичдоос суралцсан байжээ.

Энэ тогтолцооны үндэс суурь нь Бельгийн эрдэмтэн Адольф Куэтлет хүний биеийн хэмжээ өөрчлөгдөх нь тодорхой хууль тогтоомжийн дагуу явагддаг, хүн бүрийн хувьд биеийн хэсгүүдийн хэмжээсийг тус тусад нь хийх санаа сэджээ.

Ингээд хоригдлуудыг бүртгэхдээ Берилллон хэмжилтийн аргыг баяжжуулж зогсож буй өндөр, сунгасан гарны урт, суух өндөр, толгойны урт, өргөн, баруун чихний урт, өргөн, зүүн хөлний урт, дунд хурууны урт, зүүн гарын хурууны урт, зүүн гарын гарын урт, нүдний цахилдагийн өнгийг мөн тэмдэглэсэн бөгөөд үүнийг тодорхойлох тусгай хүснэгтийг боловсруулсан бөгөөд энэ өнгийг долоон бүлэгт хувааж бүртгэдэг байжээ.

Парист 1882 онд Альфонс Бертиллоны санал болгосон эрүүгийн бүртгэлийн системийг туршлагаас үндэслэн 1888 онд Францын засгийн газар баталж, зөвшөөрсөн бөгөөд энэ үеэс эхлэн гэмт хэрэгтнүүдийг бүртгэх үндсэн систем болжээ. Үүний дараа ОХУ-ын нэрт судлаач В.И.Лебедев “Гэмт хэргийг илрүүлэх урлаг” гарын авлагадаа Бериллоны системийн дагуу тусгай тэмдгийг судлах дараах журмыг зааж өгсөн байдаг: 1 - зүүн гар, 2 - баруун гар, 3 - нүүр ба хүзүү, 4 - цээж, 5 - ар тал, 6 - хөл⁶⁸ гэсэн дараалал тогтоожээ.

Үүний зэрэгцээ В.И.Лебедев өөрийн судалгааны ажлаараа тухайн этгээдийн гарын хурууны үений үрэвсэл байгаа эсэх, гарын хуруу, гарын алганы гадна болон дотор талд онцлог

⁶⁶ https://en.wikisource.org/wiki/1911_Encyclop%C3%A6dia_Britannica/Monboddo,_James_Burnett,_Lord

⁶⁷ Lombroso, C. (1876). L'uomo delinquente [Criminal man]. Milan, Italy: Hoepli

⁶⁸ См.: Лебедев В. И. Искусство раскрытия преступлений. СПб., 1912. С. 29.

содон шинж тэмдэг, шарх сорви байгаа эсэх гэх мэт өвчин эмгэг, хөхөрсөн, тайруулсан гэх мэт төрөлхийн болон үүссэн бусад шинж чанаруудыг тусгасан байна.

ОХУ-сад Антропометрийг анх 1890 онд Санкт-Петербургт нэвтрүүлсний дараа нэмж 12 антропометрийн товчоог нээв. Антропометрийн систем нь хүнийг бүртгэх, танихад чухал хэрэгсэл болж байв. Гэсэн хэдий ч нэг хүнийг дахин хэмжихдээ хэмжилт хийж байсан хүний олж авсан мэдлэг чадвараас шалгаалж үр дүн өөр өөр байсныг урьдчилан мэдэж, нэг хүний давтан хэмжилт хийх хүснэгтийг боловсруулсан хэрэглэсэн үр үртэй байв.⁶⁹

Түүнчлэн бүртгэлийн мэдээллийг зөв уншихын тулд ижил агуулгатай ижил нэр томъёог ашигласан. Альфонс Бериллилоны хэлснээр тайлбарын дараалал нь дараах байдалтай байв. Үүнд:

-Дух, хамар, баруун чих, уруул, ам, эрүү, хөмсөг, зовхи, нүдний шил, нүдний залгуур, дотогшоо, үрчлээ, нүүрний нүүрний нүүрний дүүрэн байдал, зууван.

-Нүүрний элемент бүрийг харьцангуй хэмжээ, төрөл, өнгөөр нь тэмдэглэх нь зүйтэй. Тэдгээрийн гадаад төрх шинж чанаруудыг хэдий чинээ сайн тодорхойлж чадах тусам хөрөг зураг нь амаар гарч ирэв.

Гэсэн хэдий ч амаар тайлбарлах аргачлал нь тодорхой, бодлоготой байсан ч нэлээд төвөгтэй болж хувирсан. Зөвхөн хамгийн чадварлаг ажилчид л энэ техникийг бүрэн эзэмшиж, хайлтын ажилд амжилттай хэрэгжүүлж байжээ.

Швейцарын Лозаннагийн их сургуулийн профессор Рудольф Арчибалд Рейс Алфонс Бериллилоны аргаар хүнийг таних, үүний тулд нүүрний хэсгүүдийн зургийг түүний бие даасан элементийн схем зургаар хавсаргасан байв. Рейсийн үзэж буйгаар эдгээр зурагнууд нь уншигчдын анхаарлыг тухайн хүний нүүрний онцлог шинж чанарт анхаарлаа хандуулж, түүнийг санахад нь туслах ёстой. Рейс мөн гадаад төрх тэмдгийг тодорхойлох тусгай дижитал кодыг боловсруулсан бөгөөд үүний тусламжтайгаар гэмт хэрэгтнүүдийн дүр төрхтэй холбоотой мэдээллийг телеграфаар дамжуулах боломжтой болгожээ.

Герман Улсад 1925 онд Берлиний Эрэн сурвалжлах хэлтсийн дарга Ханс Шнайкертын хүний онцлог содон шинж тэмдгүүдийн тухай сургааль ном хэвлэгджээ. Энэ бүтээлд хүний гадаад төрхийн анатомийн болон функциональ шинж тэмдгүүдийг биеийн байдал, дохио зангаа, харц, нүүрний хувирал, хөдөлгөөн, хувцаслалт зэргийг нэмж тодорхойлж гэмт хэрэгтнүүдийн дүр төрх, сураггүй алга болсон болон хэн болох нь тогтоогдоогүй цогцосыг тогтоох таних зэрэгт үр дүнтэй ашиглаж байсан нь цагдаагийн үйл ажиллагаанд ахиц гарч байжээ.⁷⁰

ОХУ-ын судлаач Н.В.Терзиев 1950 онд Шүүх эрх зүйн сурах бичигт криминалистикийн шинжилгээ хийхэд ажиглагдах ёстой үндсэн дүрмийг тусгасан. Тэрээр тэдгээрийг 1951 онд хэвлүүлсэн “Криминалистикийн тухай” сэдэвт лекцэндээ нарийвчлан тайлбарласан байдаг. Мөн 1956 онд “Гадаад дүр төрхөөр нь хүний бие махбодоор танин мэдэхүй” хэмээх бүтээлдээ нарийвчлан судалж тусган хэвлүүлжээ.

ОХУ-ын нэрт эрдэмтэн А.А Гусев 1960 онд “Гадаад төрхөөрөө таних байдлыг тогтоох зорилгоор шүүх эмнэлгийн үзлэгийг зохион байгуулах аргачлал” бүтээл нь цагдаагийн үйл ажиллагаанд ялангуяа гэмт хэрэгтэй тэмцэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

⁶⁹ https://studref.com/323712/pravo/gabitoskopiya_kriminalisticheskoe_uchenie_vneshnem_oblike_cheloveka

⁷⁰ См.: Криминалистика. Техника и тактика расследования преступлений. М., 1938. Ч. 1. Разд. 1.

Энэхүү сургалтын арга зүйн гарын авлагад тодорхой үзлэг шалгалтын үндсэн дээр зургаас гаднах шинж тэмдгийг судлах үндсэн аргуудын тодорхойлолтыг өгч, зурагнаас гаднах шинж тэмдгүүдэд дүн шинжилгээ хийх зөвлөмжийг гаргаж, шинж тэмдэг, шаардлагын найдвартай байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

ОХУ-ын эрдэмтэн А.Ю.Пересункин 1960 онд гэмт этгээдүүдийн гадаад шинж тэмдгийг судалж гадаад төрх байдлын шинж тэмдгүүдийн тогтолцоог танилцуулсан бөгөөд үүндээ анатомийн, үйл хөдлөлийн, дагалдах шинж тэмдгүүдийг тусгаж өнөөг хүртэл хөгжиж иржээ.⁷¹

АНУ-ын криминологич Готтфредсон, Хирчи нар гэмт хэрэгтнүүдийн талаарх судалгаануудаас олж мэдсэн зүйл дээр үндэслэн онол гаргахыг зорьжээ.

Тэдний судалгаагаар гэмт хэрэгтнүүд өөрийгөө хянах чадвар багатай болохыг мэдэж гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, хүйс, үндэс угсаа, гэмт хэргийн төрлөөр нь эрүүгийн үйлдэл, зан үйлийг тайлбарлажээ.

Өөрийгөө хянах чадварыг өөрсдийгөө ямар нөхцөл байдалд байгаагаас үл хамааран хүмүүс гэмт зан үйлдлээс зайлсхийх хандлага гэж тодорхойлсон.

Мөн өөрийгөө хянах чадвар багатай хүмүүсийг зан байдал, хандлагыг нарийвчлан судалж тогтоосон байна. Тухайлбал: Тэд тэсвэр хатуужил султай, хувиа хичээж хайхрамжгүй ханддаг, гэр бүл, нөхөрлөл, мэргэжлийн хувьд хэвийн байдагч ерөнхийдөө тогтворгүй хандлага илэрдэг, бухимдалд хамгийн бага тэвчих чадвартай, зөрчилдөөнд амаар бус бие махбодийн хувьд хариу үйлдэл үзүүлэх хандлагатай, эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн чадвар эзэмших, үнэлэх чадвар бага байдаг гэжээ.⁷²

Эдгээр шинж чанаруудаас шалтгаалан өөрийгөө хянах чадвар багатай хүмүүс зөвхөн гэмт хэрэгт холбогдоод зогсохгүй тамхи татах, мансууруулах бодис хэрэглэх, хууль бус бэлгийн хавьталд орох зэрэг эрсдэлтэй байдаг нь судалгаагаар нотлогджээ.⁷³

Иймд гэмт хэрэг үйлдэж болзошгүй, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн, өөрийгөө хянах чадвар султай сэтгэцийн өвчтэй зэрэг хүмүүсийн зан байдлыг судалж объектын судалгаандаа тусгах нь зүйтэй.

Шинжлэх ухаан, технологийн дэвшил, компьютерийн техник хэрэгслийг хүний үйл ажиллагааны бүхий л салбарт нэвтрүүлж XX зууны сүүлийн арван жилдүүдэд гадаад дүр төрхийг тодорхойлох, судлах ажилд компьютер ашиглах боломжийн талаар судалгаа хийж эхэлсэн бөгөөд өдгөө XXI зуунд хиймэл оюун ухаан ашиглаж төрөл бүрийн програм хангамж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Дүгнэлт

Дээрх бүхнээс дүгнэн үзвэл цагдаагийн байгууллагын объектын судалгаанд баримтлах онол, үзэл баримтлалыг эрдэмтэн, судлаачид цогц байдлаар судлаагүй, объектын судалгаанд баримтлах онол, үзэл баримтлалыг тодорхойлох, хөгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллагын объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох гэмт хэрэг үйлдэгчдийн судалгаа, архаг архичдын судалгаа, гэмт хэрэгт холбогдогчийн судалгаа, эрэн сурвалжлагдаж буй этгээдүүдийн судалгаа, түгшүүр төрүүлэгчдийн зэрэг судалгаанд дээр

⁷¹ См.: Пересункин А. Ю. Установление личности по признакам внешности (словесный портрет). М., 1960; П

⁷² Gottfredson, MR, & Hirschi T. (1990). A general theory of crime. Stanford, CA: Stanford University Press.

⁷³ Perrone, D., Sullivan, C., Pratt, TC, & Margaryan, S. (2004). Parental efficacy, self-control, and delinquent behavior: A test of a general theory of crime on a nationally-representative sample.

дурьдсан криминалистикийн дүр төрх судлалын ухааныг өргөнөөр ашиглаж үйл ажиллагаандаа хэвшүүлэн, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглаж болох юм.

Нөгөө талаар объектын судалгаанд авагдсан этгээдийн гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн дүр төрхийг судалж тогтоох нь тухайн этгээдийн болон түүний гэр бүлд байгаа хүмүүсийг гэмт хэрэгт өртөж хохирох, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байж болох юм.

Цагдаагийн байгууллагын тоо бүртгэл хийх, хөгжүүлэх, өргөтгөх, гүнзгийрүүлэх, сайжруулах, боловсронгуй болгох үйл явц нь судалгааны объектыг танин мэдэх үйл явцын дараа явагддаг процесс гэж үзэж болохоор байна.

Санал

1. Цагдаагийн байгууллагын тоо бүртгэл хөтлөх үйл ажиллагааг хөгжүүлэх, цаашид боловсронгуй болгох чиглэлээр шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа хийж, үр дүнг практикт нэвтрүүлэх;

2. Судлагдаж буй этгээдийн талаар өргөн мэдээлэл агуулсан, тухайн этгээдийн дүр төрхийг тусгасан субъектын судалгаа хийх загвар боловсруулж ашиглах;

Криминалистикийн тоо бүртгэл, хүний дүр төрх судлалын ухааныг ашиглан цагдаагийн байгууллагаас объектын судалгаа хийх ажлыг хөгжүүлэх, шинэчлэл хийх зэрэг санал дэвшүүлж байна.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮР ДҮНТЭЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭ БОЛГОН АШИГЛАХ

*ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн
дэд хурандаа Б.Наргулан*

Товчлол: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, практик үйл ажиллагааг өнөөгийн хуваагдмал байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр ашиггүй арга барилаас гарахын тулд мэдлэгт суурилсан онолын хүрээнд үндэслэх шаардлагатай байгааг сурталчлах ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд чиглэсэн нийтлэг хандлагыг даван туулахад туслах болно (жишээ нь, зохион байгуулалтын сэдэв, мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэх мэт) агуулга гэхээсээ илүү "яагаад хийх хэрэгтэй" гэхээсээ илүүтэйгээр "яаж хийх" талаар дүгнэх өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн болно.

Түлхүүр үг:

- **Crime prevention** (гэмт хэргийн урьдчилан сэргийлэл),
- **Risk factors**(эрсдэлт хүчин зүйл),
- **Situational action theory** (нөхцөл байдлын үйл ажиллагааны онол).

Үндсэн хэсэг. Гэмт хэрэг үүсгэхэд хүргэдэг тоолж баршгүй олон шалтгаан байдаг: учир нь хүмүүс ядуу, уйтгартай, гадуурхагдсан, бусдад урам зориггүй, хүчирхийлэлд өртсөн, өөрийгөө бодсон, хараа хяналтгүй, уруу татагдсан, гутаан доромжилогдсон, догдолсон, танин мэдэхүйн бэрхшээлтэй, шунахай, төөрөлдсөн, үл тоомсорлосон, эсвэл шийдвэр гаргах чадваргүй байдаг. Үүний эсрэг мөн тоолж баршгүй олон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд хийгддэг: халамжаас урьдчилан сэргийлэх, хөл хорих, чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагаа, нийгэмд хамрагдах хөтөлбөр, архитектурын дизайн, төвлөрсөн бодлогууд, зөвлөгөө, нийгмийн ур чадварын сургалт, зорилтот хатуужил, эцэг эхийн сургалт, мансууруулах бодис болон архинд донтогсодын эмчилгээ, нийгмийн тэгш байдал, шударга ёсыг сайжруулах, гудамжны гэрэлтүүлэгийг хангах эсвэл ялыг чангалах гэх мэт байна.

Үүний цаана гэмт хэргээс урьдчилан ажлын талаар авч байгаа бодлогыг боловсруулагчид болон хэрэгжүүлэгчид үр дүнтэй ажиллахын тулд янз бүрийн цогц ажлыг дэвшүүлж хэрэгжүүлэхийн тулд чармайж байгаа нь гайхах зүйл биш. Хэдийгээр криминологийн шинжлэх ухааны онол нь гэмт явдал, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогч бие хүн, тэдний онцлог байдал, төлөвших зүй тогтол, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, түүний үр дүн⁷⁴ судалдаг ба мөн гэмт явдал, түүний талаархи бидний ойлголттой холбоотой олон чухал мэдлэгийг агуулдаг ч түүний шалтгаан болон урьдчилан сэргийлэхийн доторхи ойлголтууд нь муу уялдаа холбоотой ба задарсан байдаг.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол (SAT) нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй дадлыг төвлөрүүлэх, боловсруулах, зохион байгуулахад хэрэгтэй интеграцийн цогц онол юм.

⁷⁴ Д.Зүмбэрэлхам. Криминологи. УБ.20 17 дахь тал

Гэмт хэргийн таамаглал, шалтгаан ба урьдчилан сэргийлэлт: Шалтгаан нь тухайн гэмт хэрэг үйлдэгддэг хүчин зүйл бөгөөд гэмт хэргийн таамаглах нь зүгээр л урьдчилан таамаглагч хүчин зүйл биш юм.

Урьдчилан таамаглах нь үр дүнг өөрчлөхгүй, харин шалтгааныг илрүүлэх нь өөрчилж чадна. Тиймээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд түүнийг урьдчилан таамаглах биш, харин шалтгааныг чиглүүлэх хэрэгтэй. Ихэнх эрсдэлт хүчин зүйлүүд нь урьдчилан таамаглагч гэсэн нэр томъёо боловч гэмт хэргийн шалтгаан биш юм. "Эрсдэл" гэсэн ойлголт нь зарим нэг шалтгааны үр нөлөөг илэрхийлж байгаа боловч тухайн хүний хувьд нэг юмуу олон төрлийн эрсдэлүүд нийлж гэмт хэрэг хийхэд хүргэж болох ба аль эсвэл ямар ч эрсдэлт хүчин зүйл байхгүй байж болно.

Гэмт хэрэгт үйлдэгдэж буй шалтгаан таамаглаж буй эрсдэлт хүчин зүйлсүүдийг хооронд нь ялгах хэрэгтэй ба судлаач уг шалтгааны эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэхийн тулд нарийн ажиллах шаардлагатай. Хэдийгээр гэмт хэргийн үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг урьдчилан таамаглах хүчин зүйлүүд нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашигтай байж болох хэдий ч ихэнх хүчин зүйлүүд сул талуудтай байдаг. Эдгээр гэмт хэрэгт холбогдолтой сул хүчин зүйлүүд нь хэзээ хаана гэмт хэрэг илрүүлэх илтгэх сул таамаглагч юм.

Сул талуудтай сул хүчин зүйлтэй хүүхдүүд нь өсвөр насандаа гэмт хэрэгт холбогдсон байдаг.⁷⁵ Энэхүү нийгмийн эмзэг давхаргын хүмүүсийн дийлэнх хувь нь онц хүнд гэмт хэрэг үйлдэх эсвэл гэмт хэргийн бүлэглэлд хамаарагдаж гэмт хэрэгтэн болж хувирдаг болохыг харуулж байна. Нийгмийн эмзэг бүлгээс гаралтай гэдгийг мэдэх нь түүний ирээдүйг зөв таамаглахад бидэнд тус болохгүй.

Эдгээр нөхцөлүүд нь криминологийн судалгааны ажилд болон бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарын анхаарлыг татахгүй учир тэд нарт бодит статистикийн ач холбогдол өндөртэй байх нь чухал байдаг. Иймээс гэмт хэргийн эсрэг олон төрлийн үйл ажиллагаанууд нь хүмүүсийн гэмт хэрэгтэй ямар нэгэн нөлөө дутуу эсвэл бага нөлөөтэй эрсдэлт хүчин зүйлстэй байхад чиглэгдсэн байдаг.

Хэн, хэзээ, хаана гэмт хэрэг үйлдэх нь хэдий хэрэгтэй мэдээлэл хэдий ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн чухал биш хэсэг юм. Харин түүний урьдчилсан таамаглал, шалтгаан ба урьдчилан сэргийлэх зэргийг хооронд нь ялгах нь чухал юм. Энэ талаар доорхи хүснэгт ялган оруулсан болно. /Хүснэгт 1.1/

Хэрэв ямар хүмүүс ноцтой хэрэгтэй холбогдож байгааг илрүүлэх ажиллагаанд чиглүүлэхэд тодорхой болохгүй. Харин гэмт хэрэгтэй холбогдсон хүмүүс дээр анализ хийхэд илүү тодорхой болгох боломжтой.


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахын тулд шалтгаан нөхцөл ба гэмт хэргийн таамаглалын процессыг сайн ялган ойлгох нь чухал. Мөн тэд нарыг бодлогын хүрээнд хөгжүүлж нэвтрүүлэх хэрэгтэй. Урьдчилсан сэргийлэх ажиллагааг амжилттай зохион байгуулахын тулд тухайн асуудлын хүрээнд ажиллагааг биелүүлэхийн тулд гарсан асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

Хүснэгт 1.1

⁷⁵ Gold standard or fool's gold? The pursuit of certainty in experimental criminology. Criminology and Criminal Justice, 10(1), 11–22. Johnson, M. H., & De Haan, M. (2015).

Таамаглал	Шалтгаан	Урьдчилан сэргийлэл
Хэн, хэзээ, хаана Тодорхойлолт	Яагаад Тайлбар	Юу хийх вэ? Ажилбар
Гэмт хэрэг үйлдэхэд хэн эрсдэлтэй вэ? Гэмт хэргийн хамгийн чухал үе ба байрлал?	Яагаад гэмт хэрэг болсон вэ?	Ямар бодлогууд ба хэмжилтүүд гэмт хэргийн шалтгаанд арилгах, эсрэг ажиллах эсвэл үр дүнтэйгээр шалтгааныг илрүүлэх вэ?

Үр дүнтэй гэмт хэсгээс урьдчилан сэргийлэх түлхүүр алхамууд



Эрдсэлт хүчин зүйлийн цаана: Онолын хэрэгцээ

Тодорхой болсон хязгаарлагдмал эрдсэлт хүчин зүйлийг илүү аналитик хүчин зүйлээр авснаар тодорхойлж болно. Эрдсэлт хүчин зүйлийн хамгийн дутмагшилтай тал нь түүний онолын болон уялдаа холбооны дутмагшилтай байдал юм. Гэмт хэрэгтэй холбоотой эсвэл холбоогүй биологийн, нийгмийн ба сэтгэлзүйн эрдсэлт хүчин зүйлүүд олон тооны судалгааны ажлууд хийгдэж байсан.⁷⁶ Хүйс, нас, үндэс угсаа эсвэл ажилгүйдэл эрдсэлт хүчин зүйл болохоос тухайн гэмт хэргийн шалтгаан үл болно.⁷⁷

Гэхдээ эдгээр нь аливаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийн гинжин хэлхээ болох хэдий ч улмаар сэтгэл-нийгэм зүйн хүчин зүйлийн улмаас цаашид гэмт хэрэг үйлдэх хүслийг идэвхижүүлж гэмт хэрэг үйлдэхэд хүргэнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг илүү аналитик байдлаар хийх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинжлэх ухааныг хялбаршуулах төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх практик үйл ажиллагааг илүү үр дүнтэй, үр дүнтэй болгох боломжтой юм.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол /SAT/

Хүмүүс тухайн нөхцөл байдлыг харгалзан ёс суртахууны хувьд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны хувилбар гэж үздэг (мөн холбогдох саад тотгор байхгүй) эсвэл хувийн ёс суртахууныг дагаж мөрддөггүй (өөрөөр хэлбэл өөрийгөө хянах чадваргүй байдаг) нь тэдэнд

⁷⁶ Building self-control strength: Practicing self-control leads to improved self-control performance. Journal of Experimental Social Psychology, 46(2), 465–468. Murray, J., Farrington, D. P., & Eisner, M. P. (2009).

⁷⁷ Bunge Handbook of crime correlates. San Diego: Academic Press. Farrington, D. P., Loeber, R., & Ttofi, M. M. (2012).

гэмт хэрэг үйлдэх явдал юм. Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол (SAT) нь гэмт хэргийн ерөнхий, динамик, механизмд суурилсан онол юм.⁷⁸ Үүний үндсэн таамаглал нь

- Хүмүүс тэдний үйл ажиллагааны эх үүсвэр юм тэдний үйлдлийг ойлгох, сонгох, гүйцэтгэнэ.
- Хүмүүс бол үндсэндээ дүрмээр удирдагдсан амьтад юм.
- Хүмүүс зөрчилдөөнд хариу үйлдэл үзүүлэхдээ дүрмийн заалтын дагуу өөрсдийн хүсэл эрмэлзэл (хэрэгцээ) болон амлалтаа илэрхийлнэ.

Хүний үйлдлийг тайлбарлахын тулд (тухайлбал, гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа гэх мэт) дүрмийн заалтын үйл явц хэрхэн нөлөөлж байгааг

- Хүмүүс ямар үйлдлийг өөрөөр нь хүлээж авч, үүний үндсэн дээр
- Мотивацтай холбоотой ямар сонголт хийж байгааг тэд мэдэрдэг (уруу таталт, өдөөн хатгалга)

Бүх газарт үйлдэгдэж буй гэмт хэргийн бүх үйлдэл нь хуульд заасан ёс зүйн дүрмийг зөрчдөг (тухайн нөхцөл байдалд юу хийх нь зөв, буруу болох, эс үйлдэх тухай дүрмүүд). Энэхүү нийтлэг шинж чанар нь гэмт хэргийн тухай ерөнхий онолыг боломжтой болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий хандлагыг бий болгодог.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь хүмүүсийг хууль тогтоомжид заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчихгүй байх явдал юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид үйл ажиллагааны альтернатив хувилбар, үйл ажиллагааны сонголтыг хүмүүсийн ойлголтод нөлөөлөх, ингэснээр тэд

- Тодорхой гэмт хэргийг өөр сонголт гэж үзэхгүй байх
- Хэрэв тэд үүнийг хийвэл тэд өөр хувилбар дээр ажиллахгүй байхаар шийддэг.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь нөхцөл байдлын хүмүүсийн үйл ажиллагааны хувилбаруудын талаархи тодорхой ойлголт, үйл ажиллагааг сонгох, хэрэгжүүлэх үйл явцыг өдөөж, хүн ба хүрээлэн буй орчны харилцан үйлчлэлийн холбогдох оролтыг удирдан чиглүүлэх ажиллагааны шалтгааныг нотолдог. Энэхүү таамаглалыг РЕА-ийн таамаглалд тусгасан бөгөөд:

Үүнд ямар нэгэн тодорхой мотивац (уруу таталт, өдөөн хатгалга): үүссэн үйлдэл (А) нь хувийн мэдрэмж (Р) ба хүрээлэн буй орчны холбогдох өдөөлтөд өртөх (Е) холбогдох хоорондын харилцан хамаарлын (х) үр дүнд үүссэн ойлголт-сонгох процессын ($\rightarrow$) Үр дүн юм.⁷⁹

$$P \times E \rightarrow A$$

Ойлголтыг сонгох үйл явцын гол элементүүд нь мотиваци, ёс суртахууны шүүлтүүр, хяналт юм. Хүсэл эрмэлзэл (уруу таталт эсвэл өдөөн хатгалга) нь зорилгод чиглүүлэх замаар (шаардлагатай боловч хангалтгүй хүчин зүйл) үйл ажиллагааны процессыг эхлүүлдэг. Ёс суртахууны шүүлтүүр нь тухайн хүний хүсэл эрмэлзэлтэй холбоотой хариу үйлдлийг түүний хувийн ёс суртахуун ба тухайн үеийн ёс суртахууны хэм хэмжээ хоорондын харилцан үйлчлэлийн үр дүн гэж үздэг үйл ажиллагааны хувилбаруудыг тодорхойлдог.

Хяналт (өөрийгөө хянах, таслан зогсоох) нь үйл ажиллагааны талаархи өөр хувилбаруудын талаар зөрчилтэй дүрмийн удирдамж гарч, хүмүүсийг зориуд (аль хувилбарыг нь илүүд үздэгийг идэвхтэй үнэлэх) хүргэдэг зөрчилдөөний үед л сонгох үйл явцад нөлөөлдөг.

⁷⁸ Antisocial behaviour and crime: Contributions of developmental and evaluation research to prevention and intervention (pp. 109–122). Cambridge, MA: Hogrefe Publishing. Wikström, P.-O. H. (2014).

⁷⁹ Long-term potentiation—A decade of progress? Science, 285 (5435), 1870–1874. Moffitt, T. E., & Henry, B. (1989).

Ойлгох сонголт хийх үйл явц нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалан их бага хэмжээгээр зориуд (оновчтой) эсвэл автоматжуулсан (зөн совингоор) байж болно.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь хүмүүс гэмт хэргийн янз бүрийн хандлагатай байдаг гэж үздэг (тодорхой гэмт хэргүүдийг үйл ажиллагааны хувилбар болгон харах, сонгох хандлага). Хүмүүс үндсэндээ дүрмээр удирддаг жүжигчид гэсэн таамаглал дээр үндэслэн нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь тухайн хүний гэмт хэргийн хандлагыг тодорхойлдог хувь хүний гол шинж чанаруудыг санал болгодог.

- Хувийн ёс суртахуун (тодорхой нөхцөлд юу хийх нь зөв эсвэл буруу болох талаархи үнэ цэнэ дээр суурилсан ёс зүйн дүрэм)
- Хүний гүйцэтгэх чиг үүрэг, хордлого, сэтгэл хөдлөл, стрессийн өндөр зэрэг хүчин зүйлээс бүрдсэн биеэ хянах чадвар (өөрөөр хэлбэл, гадны зүгээс шахалт үзүүлэх тохиолдолд хувийн ёс суртахууныг дагаж мөрдөх).

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь хүний ёс суртахуун ба өөрийгөө хянах чадварыг ёс суртахууны боловсрол, танин мэдэхүйн хүмүүжлийн явцад олж авдаг тул эдгээр үйл явцад нөлөөлөх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц бодлогын чухал хэсэг байх ёстой гэж санал болгож байна.

Орчин (газар, тохиргоо) нь криминоген шинж чанараараа (гэмт хэргийн шинж чанарыг хэр зэрэг хөхиүлэн дэмжиж, ядаж сэтгэлээр унагаахгүй) ялгаатай байдаг. Хүмүүс дүрмийн удирдлагад нийцсэн жүжигчид гэсэн таамаглалд үндэслэн нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь тухайн газар (орчин) -ны криминоген⁸⁰ чанарыг тодорхойлдог чухал шинж чанарууд нь дараахь зүйлийг санал болгож байна.

- Ёс суртахууны хэм хэмжээ (тодорхой хүсэл эрмэлзэл дээр тулгуурлан ажиллахтай холбоотой нийтлэг журам)
- Дүрмийн хэрэгжилт (хамтын зан үйлийн дүрмийг зөрчихөд учирсан үр дагаврын хамаарал ба хатуу байдал)

Тиймээс нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь ёс суртахууны хэм хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтэд нөлөөлөх нь гэмт хэргийн үйлдлийг таслан зогсооход нөлөөлөх нь урьдчилан сэргийлэх цогц бодлогын гол хэсэг байх ёстой байна. Хүмүүс нийгмийн амьдралдаа харилцан адилгүй байдаг бөгөөд ингэснээр криминогенийн тохиргоонд өртдөг. Хүний криминогенийн тохиргоонд өртөх байдал нь нийгмийн болон өөрийгөө сонгох үйл явцаас хамаарна. Тиймээс нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гурав дахь гол зорилго нь эдгээр үйл явцад нөлөөлөх, ингэснээр хүмүүсийн криминогенийн орчинд хамгийн бага өртөх боломжийг багасгахыг зөвлөж байна.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онолыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй хөгжлийн хүрээ болгон ашиглах

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй урьдчилан сэргийлэх нь

- Хүмүүсийн гэмт хэрэг үйлдэх хандлагыг өөрчилж, өөрөөр хэлбэл тэдний хууль тогтоомжид хамаарах хувийн ёс суртахуун, өөрийгөө хянах чадварыг өөрчлөх замаар гэмт хэрэгтэй холбоотой ойлголтыг сонгох үйл явцад амжилттай оруулсан бодлого, арга хэмжээг шаарддаг

⁸⁰ Гэмт хэргийн хандлагыг үүсгэх хүчин зүйл

- Тохиргооны криминоген өдөөлтийг өөрчлөх, өөрөөр хэлбэл тэдний мотивацт (боломж ба үрэлт) ба ёс суртахууны нөхцөл байдал (ёс суртахууны хэм хэмжээ, түүний хэрэгжилт), холбогдох нийгэм-экологийн үйл явцад үр дүнтэй нөлөөлөх, эсвэл тэдний нийгмийн үр дагаврыг эсэргүүцэх замаар өөрчлөх;
- Нийгмийн болон өөрийгөө сонгох холбогдох үйл явцад нөлөөлөх замаар хүмүүсийн криминоген орчин, өөрөөр хэлбэл тэдний үйл ажиллагааны талбарт нөлөөлөх байдлыг өөрчлөх зэрэг орно.

Дүгнэлт. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, практик үйл ажиллагааг өнөөгийн хуваагдмал байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр ашиггүй арга барилаас гарахын тулд мэдлэгт суурилсан онолын хүрээнд үндэслэх шаардлагатай байгааг сурталчлах ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд чиглэсэн нийтлэг хандлагыг даван туулахад туслах болно. Жишээ нь, зохион байгуулалтын сэдэв, мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэх мэт) агуулга гэхээсээ илүү "яагаад хийх хэрэгтэй" гэхээсээ илүүтэйгээр "яаж хийх" талаар дүгнэх шаардлагатай.

Нөхцөл байдлын үйл ажиллагааны онол нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаанд хэрхэн анхаарлаа төвлөрүүлж, удирдан чиглүүлэхэд тусалж болохыг тоймлов. Хүмүүсийн үйлдлийг (гэмт хэргийн үйлдлийг) өөрчлөхийн тулд бид дараахь зүйлийг хийх боломжтой.

- Хүмүүсийг өөрчлөх (хувийн ёс суртахуун, өөрийгөө хянах чадварыг өөрчлөх)
- Газраа өөрчлөх (ёс суртахууны нөхцөл байдал, хэрэгжилтийг өөрчлөх)
- Хүмүүсийн газруудад үзүүлэх нөлөөллийг өөрчлөх (нийгмийн болон өөрийгөө сонгох үйл явцыг өөрчлөх)

Санал. Ийм өөрчлөлтийг үндсэндээ амжилттай хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний үр дүнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

- Гэмт хэргийг хүлээн зөвшөөрөхгүй авир гэж хүмүүсийн ойлголтыг сурталчлах (ёс суртахууны боловсрол олгох замаар)
- Хүмүүсийн хууль зөрчих гадны өдөөн хатгалгыг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх (танин мэдэхүйн хүмүүжил олгох замаар)
- Хуульд заасан ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх орчны чадавхийг бэхжүүлэх (нийтлэг ёс суртахууны дүрмийг бий болгох, тэдгээрийн хэрэгжилтийг дэмжих замаар)
- Хүмүүсийн криминогенийн орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах (нийгмийн болон өөрийгөө сонгох үйл явцад нөлөөлөх замаар) ингэснээр энэ нь гол байх ёстой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны гол чиглэл юм.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, механизмыг илүү сайн ойлгохын тулд эрсдэлт хүчин зүйлээс хэтэрч, онолын хатуу шалгалт, үнэлгээний судалгаа хийх замаар мэдлэг, нотолгооны суурийг бүрдүүлэхийн зэрэгцээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх практик үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ийм тогтолцоог ашиглах нь нэн чухал гэж бид үзэж байна.

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙ БА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

ДХИС-ийн магистрант М.Уянга

Товчлол. Энэхүү өгүүлэлд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай ойлголт, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, ОХУ болон Филиппин улсуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр явуулж буй байгууллагын зарим үйл ажиллагаа, туршлага, хүрсэн үр дүнгийн талаар товч авч үзсэн болно

Түлхүүр үг: эрэн сурвалжлах сэтгүүл зүй, гэмт хэрэг, зөрчил

Удиртгал: Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн хувийн аюулгүй байдалд халдсан хэрэг, мөн мөрдөх, баривчлах, хорих, мэдээлэл өгөхөөс татгалзах зэргээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжид сөргөөр нөлөөлөх, сэтгүүлчдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгахгүй, эрэн сурвалжлах арга хэмжээ авалгүй орхидог хэргийн тоо санаа зовохуйц хэмжээнд өсөх хандлагатай байна.

Нөгөө талаараа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн салбар, тэр дундаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлчидтэй салшгүй холбоотой юм.

ЮНЕСКО болон Сэтгүүлчдийг хамгаалах Хороо (CPJ), Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF), Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын институт (INSI), Үзэл бодлын чөлөөт илэрхийллийг дэмжин хамгаалах олон улсын сүлжээ (IFEX), Бүх Америкийн хэвлэлийн нийгэмлэг (IAPA) зэрэг бусад байгууллагын цуглуулсан мэдээ баримтад мэргэжлийн үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн талаар айдас төрүүлэхүйц тоо баримт дурдагдах болов.

Нөгөө талаар сэтгүүл зүй гэж юу болох, түүний үр нөлөө хэрхэн нийгэмд нөлөөлж байгаа болон түүнийг нийгэмд бүтээмжтэй байдлаар ашиглаж болох талаар судалгаа хийж, үр дүнтэй нэвтрүүлэх явдал өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болжээ.

Сэдвийн хамрах хүрээ: Энэхүү өгүүллийн сэдвийн хамрах хүрээ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өнөөгийн байдал, нийгэмд үзүүлэх үүрэг оролцоо, ач холбогдол болон ОХУ болон Филиппин улсуудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээгээр сэдвийн хамрах хүрээ тодорхойлогдож байна.

Үндсэн хэсэг. Сэтгүүл зүйн шинжлэх ухаан бол юуны өмнө олон түмэнд хандсан, тэдний нийгмийн амьдралд болон ухамсарт нөлөөлөхүйц чухал гэж үзсэн баримт, асуудал, үйл явдал, үзэгдлүүдийг маш өргөн хүрээнд тусгасан, түүгээр дамжуулан тогтмол хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэг, цахим хэвлэлийн бүтээгдэхүүнд өдөр тутмын нийгмийн амьдралын дүр зураг, орчин цагийн дүр төрхийг бүтээж чаддагаараа онцлог юм.

Сэтгүүл зүй бол “journalist” – Францын journal – “өдрийн тэмдэглэл”, jour – “өдөр”, латины diurnal – “өдөр тутмын” гэсэн үгнээс гаралтай юм.⁸¹

Сэтгүүл зүйн үүргийг өргөн утгаар авч үзвэл “түүний зайлшгүй хийх зүйлийн нийлбэр ба түүнийг биелүүлэх үйл явцын шинж чанар мөн.”⁸²

Сэтгүүл зүйн нийгэмд эзлэх байр, үр нөлөө, сэтгүүлчдийн үйл ажиллагааны онцлог зэрэг нь түүний үүргээр дамжин тодорхойлогддог.

Орчин үед сэтгүүл зүй мэдээлэх, танин мэдүүлэх (соён гэгээрүүлэх), удирдлагын хэрэгсэл болох (нийгмийн санаа бодолд нөлөөлөх, “дөрөв дэх засаглал”), хяналтын (зохион байгуулах), харилцааны болон зугаацуулах зэрэг үндсэн үүргүүдийг гүйцэтгэж байна гэж үзэх үндэстэй юм.⁸³

Сэтгүүл зүйн шинжлэх ухаанд үндсэн категориуд болгон мэдээлэл, эрх чөлөө, үүрэг, зарчим, үр нөлөө, үр ашиг зэрэг ерөнхий ойлголтуудыг авч үздэг. Сэтгүүл зүй нийгмийн үүргээ зөвхөн мэдээллээр дамжуулан биелүүлдэг онцлогтой юм.

Мэдээлэл нь сэтгүүл зүй, олон нийт хоёрыг шууд холбогчийн үүргийг гүйцэтгэдэг хэрэгсэл бөгөөд түүний тусламжтайгаар нийгмийн өвөрмөц институт болох сэтгүүл зүйн системийн бараг бүх асуудлыг шийдвэрлэдэг.⁸⁴

Сэтгүүл зүй нийгмийн үйл ажиллагааны өвөрмөц салбар бөгөөд тэр онцлог нь түүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, эвлүүлэх, түгээх үйл ажиллагааны явцад улам тод илэрдэг.

Мэдээллийг түргэн шуурхай түгээхээс илүү нягталсан баталгаатай мэдээллийг түгээх нь сэтгүүл зүйн хэв мэдээллийн нэн тэргүүний зорилт юм. Дижитал хувьсал, алгоритм, технологийн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн том сорилт бол нийгмийн хэвлэл мэдээлэл (Сошиал медиа) болж байна. Уламжлалт сэтгүүл зүйн ноёрхлын үед зөвхөн сэтгүүлчид мэдээлэлд хүрч, түүнийг боловсруулж олон нийтэд хүргэдэг байсан бол өнөөдөр байдал эрс өөрчлөгджээ. Хэрэглэгчид мэдээллийн эх сурвалж болохоос гадна мэдээллийг түгээгч, дамжуулагч, иэдвхитэй хуваалцагч болж байна.⁸⁵

Сэтгүүл зүйн олон төрөл, хэлбэр байдаг бөгөөд түүний нэг нэгж хэсэг болох эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нийгэмд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг төрөл юм.

Манай оронд 1980-иад оны дунд үеэс эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурь тавигдсан. Өнөөдөр энэ чиглэлээр ажиллах сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн тоо нэмэгдэж орчин үед нэлээд эрчимтэй хөгжих хандлага ажиглагдаж эхэлсэн байна.

Тухайлбал, Ц.Балдоржийн “Далай ээж цаазын тавцан”, Ж.Барамсай “Шорон дотроос өшөө авагч байдаг юм биш биз?”, Ц.Оюундарийн “Зууны шилдэг луйвар” зэрэг нийтлэл гарч байсныг дурдаж болохоос гадна доктор Д.Цэмбэл, До.Цэнджав нарын “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол практикийн асуудал”, СГЗ доктор /Sc.D/ профессор М.Зулькафиль “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн олон, практикийн арга зүй”, доктор Ч.Базарын “Хэрхэн эрэн

⁸¹ Болд-Эрдэнэ Б, Зулькафиль М, Мэндхүү Г, Наранбаатар Б, Норовсүрэн Л, Өнөрсайхан Т. Сэтгүүл зүйн үндэс. УБ. 2021. 10 дахь тал

⁸² Прохоров Е.Л. 1998. Введение в теорию журналистики. М., с. 98

⁸³ Болд-Эрдэнэ Б, Зулькафиль М, Мэндхүү Г, Наранбаатар Б, Норовсүрэн Л, Өнөрсайхан Т. Сэтгүүл зүйн үндэс. УБ. 2021.

⁸⁴ Мөн бүтээл. 18 дахь тал

⁸⁵ Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцийн баримтлах бодлого. /Редактор, сурвалжлагчдад зориулсан зөвлөмж/. УБ. 2020. 4 дэх тал

сурвалжлага хийх вэ?” зэрэг олон арван бүтээл гарсан байна. Манай орны эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүсэл хөгжлийг дараах гурван үе шаттад хуваадаг. Үүнд:

1921-1980 он: Энэ үеэд хэдийгээр нэг намын үзэл суртал ноёрхож байсан боловч манай зарим томоохон хэвлэлүүдэд эрэн сурвалжлах аргыг ашигласан асуудал дэвшүүлсэн шүүмжлэлт нийтлэлүүд гарч байсан. Тухайн үед эрэн сурвалжлах, эсвэл судалгааны сэтгүүл зүй хэмээх нэр томъёо байгаагүй учир ийм нийтлэлүүдийг өөрөөр гол төлөв илчлэн шүүмжлэх нийтлэл гэж нэрлэж байсан байна.

1980-1990 он: 80-иад оны дунд үеэс орон даяар өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн үйл явц Манай сэтгүүл зүйн цоо шинэ уур амьсгалыг авч ирсэн бөгөөд чухам энэ үед ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлэгт ил тод, олон ургальч шинж нэвтэрч олон жилийн турш далд нуугдмал байдалд байсан сэдвүүдийг хөндөж, ноцтой баримтуудыг илчилж эхэлсэн юм.

1990 оноос хойших үе: Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжиж ирсэн үе. Энэ үеэд чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих шинэ нөхцөл боломжийг бий болгосон. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд эрэн сурвалжлах алба байгуулж, сэтгүүлчид энэ чиглэлээр мэргэших шинэ боломж нэгдэхийн хамт их дээд сургуулиудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хичээл орж, зарим сургуулиуд сэтгүүлчдийг тусгайлан бэлтгэх оролдлого хийж эхлэсэн.

Мөн зөвхөн сонин хэвлэл тогтмол хэвлэл төдийгүй, радио телевизүүд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлд идэвхитэй алхам хийж “Хар цагаан”, “Зууны шилдэг луйвар” зэрэг цуврал нэвтрүүлэг бэлтгэсэн нь тухайн үед шинэлэг зүйл байсан.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь сэтгүүлчийн идэвхтэй үйл ажиллагаа, мэдээллийн нээлттэй, цогц эх сурвалжийн орчин, иргэний эрх зүйт нийгэмд бодитой оршдог сэтгүүл зүй юм.

АНУ-ын эрэн сурвалжлах нийгэмлэгийг үндэслэгч Роберт Грин “Тодорхой хувь хүн, байгууллагын нууцлахыг хүсч буй мэдээллийн гүнд нэвтэрч, нийгмийн эрх ашгийг хөндсөн чухал асуудлыг дэлгэж тавих зорилгот нийтлэл, нэвтрүүлгийг эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг.⁸⁶

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн сүлжээний (GIJN) үүсгэн байгуулагчдын нэг, "Таамагт суурилсан судалгаа" номын зохиогч, сэтгүүлч Марк Ли Хантер "Эрэн сурвалжлах сэтгүүлзүй аливаа далд асуудлыг олон нийтэд ил болгоход чиглэдэг. Ийнхүү далд орсон мэдээлэл нь хэн нэгний эрх мэдлээ урвуулан ашигласантай холбоотой байж ч болно, эсхүл зүгээр л ойлгоход хэцүү, замбараагүй олон мэдээллийн дунд гээгдсэн байж болно. Эрэн сурвалжлах сэтгүүлзүй нууц болон нээлттэй эх сурвалжийн аль алиныг нь ашигладаг" гэсэн байдаг.

Английн нэрт сэтгүүлч Дэвид Рэндал “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн зорилго нь “албан хаагч, төр захиргааны ажилтнуудын нуухыг хичээж буй мэдээллийг ил гаргах, хүмүүсийн амьдрал, нийгэмд нөлөөлөх үйл явдал, туршлагуудын тухай мэдээлэх, эрх баригчдын авилга, улсын хөрөнгийг үр ашиггүй зүйлд цацах зэрэг буруу үйлдлийг хянаж байхад оршдог”⁸⁷ гэжээ.

Глоб интернэшнл ТББ-ын тэргүүн Х.Нарангэрэл "Асуудлыг гаргаж тавих бус асуудлыг судалж шинжилдэг шинжилдэг. Асуудлыг бүх талаас нь судалдаг" гэжээ.

⁸⁶ <https://mn.wikipedia.org/wiki/>

⁸⁷ <https://mn.wikipedia.org/wiki/>

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нийтлэл нэвтрүүлгийн сэдэв нь олон түмний эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, нийгмийн ач холбогдол өндөр, хүлээн авагчдын сэтгэхүйд нөлөөлөх чадвар сайтай байх, сэтгүүлчийн тусгаж буй баримтыг хувь хүн, байгууллага олон нийтээс нуухыг эрмэллэж байх гэсэн гурван гол шинжийг өөртөө агуулсан байдаг.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нийгмийн үр нөлөө өсөхийн хэрээр судлаач шүүмжлэгчдийн анхааралд өртөн, түүний талаар олон янзын шүүмж гарах болжээ. Тухайлбал АНУ-ын баруун хойт мужийн их сургуулийн эрдэмтэд, профессор Дэвид Протесс ба түүний удирдсан бүлэг судлаач хэдэн жилийн турш эрэн сурвалжилга хийсэн сэтгүүлчдийн дунд асуулга явуулсны дүнд олдсон мэдээ, мөн түүнчлэн уншигч, телевиз үзэгчдийн дунд хийсэн ажиглалтдаа үндэслэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай бичиж, тодорхой дүгнэлтүүд гаргасан байна. Тэдгээрийн заримыг дурдвал, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сэдвүүд нь хэд хэдэн эх сурвалжаас үүдэн гардаг, эрэн сурвалжлах ажлын бэрхшээлийг харилцан буулт хийх замаар даван туулна, илчлэх бүтээл гарахад янз янзаар л ханддаг, эрэн сурвалжлагын үр дүнг нийтлэхэд уг байдлыг өөрчлөх гэсэн олон нийтийн шаардлага хааяа өрнөх үе бий, харин албан тушаалтан, байгууллагууд нийтлэгдсэн материалын талаар янз бүрийн учир шалтгаан зааж, хариу өгдөг бөгөөд заримдаа арга хэмжээ авдаг” гэжээ.⁸⁸

Өнөөдөр манай улсын хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарт дараах үндсэн зарчмыг баримтлан ажиллаж байна. Үүнд:

д/д	Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын баримтлах зарчим	Тайлбар
1	Үнэн бодитой байх	Сэтгүүл зүйн хувь заяа түүний мэдээллийн үнэн бодитой байх эсэхээс шууд шалтгаалдаг. Ер нь сэтгүүл зүйн эцсийн зорилго ч олон түмнийг үнэн бодитой мэдээллээр хангахад оршдог. Сэтгүүл зүйн үнэн бодитой байх зарчмаас бусад бүх зарчим нь шууд шалтгаална.
2	Шуурхай, хүртээмжтэй байх	Зарчим нэгэнт сэтгүүл зүйн үйл ажиллагааны арга зүйн үндэс болохоор шуурхай байх явдал сэтгүүлчийн үйл ажиллагааны бүх үе шатанд нэгэн адил хамаарна. Мөн мэдээллийн хүртээмжтэй байх эсэхээс түүний үр нөлөө, өгөөж нь шууд шалтгаална. Хүртээмжтэй байх гэдэг нь нэг талаар тухайн мэдээлэл нэгэн зэрэг олон хүнийг хамрах боломжтой байх, нөгөө талаар ямар ч хүн уншиж, үзэж, сонсож ойлгох боломжтой гэсэн үг юм.
3	Ил тод, олон ургальч шинжтэй байх	Энэ зарчмын агуулга нь сэтгүүл зүй төрийн үйл ажиллагааг удирдах үйл явцад шууд оролцоход орших бөгөөд ингэснээр ардчиллын тодорхой нэг илрэл болдог. Сэтгүүл зүй нь ардчиллыг хэрэгжүүлэх, засгийн үйл ажиллагаанд оролцох ажлыг олон түмэнтэй байнгын харилцаа холбоотой байх явцад ажигласан редакцийн шуудан болон бусад баталгаатай эх сурвалжаас олж авсан ард түмний аж байдал, хэрэгцээ шаардлагыг нийтлэл нэвтрүүлэгт тусгах замаар тэдний нэрийн өмнөөс ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг илэрхийлэгч, дамжуулагчийн үүргийг гүйцэтгэдэг.
4	Олон нийтэгч байх	Ардчилсан сэтгүүл зүйн баримтлах өөр нэг чухал зарчим бол түүний олон нийтэгч зарчим юм. Энэ зарчим нь сэтгүүл зүй, олон түмнийг өргөн хамарч, тэд мэдээллийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох замаар илэрдэг.
5	Хүнлэг байх	Энэ зарчим нь сэтгүүл зүй, хүн хоёрын хоорондох харилцааг илэрхийлэх төдийгүй бусад зарчмуудын үйл ажиллагааны нэгдмэл чанар, үр дүнгийн илэрхийлэл болдог. Сэтгүүлчийн бүх үйл ажиллагаа ирээдүйд чиглэсэн, бүтээлч, өнөөдрийн хүнд онцгой анхаарал тавихыг шаардсан хүнлэг, энэрэнгүй

⁸⁸ <https://mn.wikipedia.org/wiki/>

		үзэл нэвт шингэсэн байх ёстой.
6	Тэнцэрт байдлыг хадгалах	Аливаа асуудалд шударга бус хандах нь уншигчдад буруу зөрүү ойлголт өгөх, төөрөгдүүлэх, нийгэмд эрүүл бус уур амьсгал бий болгох сөрөг талтай. Тэнцвэрт байдлыг хадгалах зарчим ил тод байх, олон ургальч үзлийн индэр байх зарчмуудтай холбоотой бөгөөд тэднийг практикт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл аливаа баримт, үйл явдлыг шударга, адил тэгш тусгах замаар олон түмэнд үнэн зөв мэдээлэл өгч, сэтгэл зүйг зөв гольдролд чиглүүдэгт тус зарчмын агуулга оршино.

Дээрхи зарчмууд нь хатуу тогтоосон тоо биш бөгөөд манай орны өнөөгийн нөхцөлд чөлөөт хэвлэлийн хувьд баримталж буй гол зарчмууд юм.

Өнөөдөр бараг бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл цахим хувилбартай болж, шуурхай, хүртээмжтэй байхын төлөө хүчтэй өрсөлдөх болсон. Энэ бүхэн нь ижилсэл буюу конвергенци⁸⁹йн илрэл юм. Түүнчлэн сүүлийн үед нэлээд эрчимтэй илэрч буй хандлага бол төвлөрөл юм. Энэ бол нэг компани, эсвэл нэг хүний гарт хэд, хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл төвлөрөх дурдаж болно. Өнөөдөр дэлхий дахинд “Ньюз корпорейшн”, “Бетельсман”, “Тайм-Уорнер”, “Уолт Дисней” зэрэг зургаан медиа магнат хэвлэл мэдээллийн хандлагыг тодорхойлж байна.

Манай улсад ч гэсэн тийм хандлага ажиглагдаж эхэлсэн байдаг. Тухайлбал, “Монголньюс”, “Монгол масс медиа”, “Масс медиа”, “Медиа групп”, “Женко”, “Гэрэл палас” зэрэг тус бүр нь 10-аад хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэд хэдэн медиа групп үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл дампуурахгүй байх сайн талтай боловч тэр группийн эзэд, ард нь байгаа улстөрч, бизнесменүүдийн үзэл бодол, дуу хоолойн индэр болж, мэдээллийн тэнцвэрт байдал алдагдах, нэг талыг барьж туйлшрах сөрөг талтай.⁹⁰

“Сэтгүүл зүйд байх шохоорхлын хэм хэмжээ нь тэдгээр баримтыг цаагуураа үндэслэлтэй болгодог. Гагцхүү тэдгээрийг нэгтгэн дүгнэх хийгээд гаднах үндэслэл нь эргэлзээтэй байж болох талтай. Энэ нь сэтгүүлчид хэрэг явдлын ижил болон ялгаатай, эерэг болон сөрөг, эсвэл төсөөтэй байдлыг сайтар анзаарахгүй, харин тусгай, тусгай баримтыг илүү анхаардагт хамаг учир нь оршиж байдагтай холбоотой” гэж Оросын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвийн захирал А. Константинов хэлсэн байдаг.

Зарим судлаачид эрэн сурвалжлах сэтгүүл зүйг “гүн ухаан, философийг өөртөө нэвт шингээсэн сэтгүүл зүй” гэж үнэлдэг тал ч бий. Барууны сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүргийг:

- Албан тушаалтнуудын хаацайлан далдлахыг хүсэж байгаа нууцлаг зүйлийг ил гаргаж тавих;
- Далд сэдвийг дэлгэх замаар түүнд олон түмний анхаарлыг хандуулж, улмаар тэдний хяналтыг бий болгох;
- Эх сурвалжийн баримт мэдээлэлд тулгуурлан тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг гаргаж тавих;
- Төр засаг болон бусад аж ахуйн байгууллагуудын үйлдэлд хэвлэл мэдээллийн хяналт тавих гэх зэргээр тодорхойлжээ.

⁸⁹ The **конвергент хувьсал** Энэ нь бие даасан байдлаар хоёр ба түүнээс дээш удамд фенотипийн ижил төстэй байдал үүсэх явдал юм. Ерөнхийдөө энэ хэв шинжийг оролцогч бүлгүүд ижил төстэй орчин, бичил орчин эсвэл ижил төстэй сонгомол даралтад шилжих амьдралын хэв маягаар нөлөөлөх үед ажиглагддаг.

⁹⁰ <https://ikon.mn/n/xwl>

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нийгмийн өмнө хүлээсэн сэтгүүл зүйн хоточ нохойн үүргийг хамгийн сайн биелүүлдэг гэж үздэг.⁹¹

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр гадаадын зарим орны туршлагыг судалж үзвэл:

Филлипин улс. 1990-ээд оны сүүлчээр Шейла Коронел, Ивон Чува тэргүүтэй дөрвөн сэтгүүлч Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвийг санаачлан байгуулж, өөрсдийн үйл ажиллагааг ерөнхийлөгч Жозеф Эстрадагийн хууль бусаар хөрөнгө, орлогоо бэхжүүлж, авилгалын хэргийг өөгшүүлж буй хэрэгт чиглүүлэн ажиллажээ.

Тэр тухайн улс оронд бөөн хардлага, сэрдлэ, гудамжны хов живээс өөр барих барьцгүй байсан үйл явдлын араас олон сарын турш уйгагүй эрэн сурвалжилсаны эцэст ерөнхийлөгч хэдэн тэрбум пэсогийн хээл хахууль, авилгал авч байсан хэргийг илрүүлэн бичжээ.

Энэхүү цуврал бүтээл нь олон түмнийг ерөнхийлөгчөө огцруулах хөдөлгөөнд оруулаад зогсоогүй эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хуулийн хэрэгжилт маш сул дорой, авилгалд идэгдсэн, танил талын хэлхээ холбоо дэндүү хөгжсөн нийгэмд хүртэл асар их нөлөө үзүүлж чаддаг гэдгийг харуулж, бас батласнаараа бусдад үлгэр загвар болжээ.

Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвөөс нийтлэн гаргасан эхний гурван сурвалжлага нь л Эстрадагийн эсрэг шүүх ажиллагааны гол бааз суурь нь болсон байна. Тэрхүү шүүх ажиллагааны эцэст хэдэн сарын дараа Ерөнхийлөгч Эстрада огцорч, ФЭССЗТ-ийн бүтээл нь шүүмжлэхээс ямагт цэрвэдэг байсан Филиппиний хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулахад хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Энэ үеэс л Филиппинд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хүчтэй хөгжиж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв нь сургалт, судалгааны үйл ажиллагааг давхар хийх болжээ. Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвийн хийсэн эрэн сурвалжилга нь сэтгүүл зүйн судалгааны үнэтэй арга зүй төдийгүй улс төр, хууль эрх зүй, нийгмийн үр нөлөөгөөрөө асар их ач холбогдолтой бүтээлүүд болсон билээ.

Нэгдүгээрт, хэвлэл мэдээлэл асар их үүрэг, хариуцлагатай байдгийг нийгэмд мэдрүүлж, олон түмэн хэвлэл мэдээллийг дөрөв дэх засаглалын хэмжээнд хүлээн зөвшөөрөхөд ихээхэн түлхэц өгчээ. Шүүмжлэхээс ямагт цэрвэдэг байсан Филиппиний хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөдөлгөөнд орж, өмнө нь Ерөнхийлөгчид тал заслаа хэмээн шүүмжлэгддэг байсан хэвлэлүүд зориг орж, Ерөнхийлөгч болон түүний тойрон хүрээлэгчдийг ухаж төнхөн, эрэн сурвалжилга хийх болжээ. Тэр үед дөрвөн сэтгүүлчийн ахлагч, Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвийн захирал Коронел “Одоо хүн бүр л Эстрадагийн нууц амрагуудын байшинг олж илрүүлэхийг хичээж байна. Хэвлэл мэдээллийнхэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйг үнэлж сурч байна” хэмээн онцлон тэмдэглэжээ.

Хоёрдугаарт, Сэтгүүлчдийн эрэн сурвалжилсан бүтээл нь маш их эрх мэдэл, мөнгө хөрөнгийг өөртөө хуримтлуулж чадсан хүчирхэг Ерөнхийлөгчийн эсрэг шүүх хэрхэн шударгаар ажиллахыг олон түмэн харж, хяналтаа тогтооход ихээхэн тус үзүүлсэн юм. Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төвөөс хэвлэн гаргасан эхний гурван сурвалжлага нь Эстрадагийн эсрэг шүүх ажиллагааны гол бааз суурь болсон байна. Шүүх Жозеф Эстрадад авилга, хээл хахуульд автсан, олон түмний итгэлийг хөсөрдүүлсэн, Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр ял тулгасан байна. Ялын үндэслэлийн гурав нь сэтгүүлчдийн сурвалжилгад

⁹¹ <https://mn.wikipedia.org/wiki/>

суурилжээ. Шүүх ажиллагааны эцэст хэдэн сарын дараа Ерөнхийлөгч зөөлөн суудлаасаа огцорчээ.

Гуравдугаарт, сэтгүүлчдийн эрэн сурвалжилсан бүтээл нь ард түмэн Ерөнхийлөгч сонгогчдынхоо итгэлийг хэрхэн хөсөрдүүлснийг баримт нотолгоотойгоор мэдэж, улмаар түүнд хяналт тавьж, басхүү сонгосон ч эргүүлэн огцруулж чаддаг өөрсдийнх нь хүч чадлыг мэдрүүлж өгчээ.

Дөрөвдүгээрт, сэтгүүлчдийн эрэн сурвалжилсан бүтээл нь дэлхий дахинд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хүч чадал, ач холбогдлыг мэдрүүлэхэд түлхэц өгсөн юм. Тэрч утгаараа Филиппиний дөрвөн сэтгүүлч эрэн сурвалжлах сэтгүүл зүйн Жэйм В.Онгпины уралдааны тэргүүн шагналыг 2001 онд авчээ. “Урьд өмнө сэтгүүл зүйн чиглэлээр гарч байгаагүй гойд сайн судалгаа хийж, баримтаар нотлон, ур чадварын дээдийг харуулсан бүтээлүүд” гэж тус төвийнхний тухай дэлхий нийтээр бичиж байна.

Сэтгүүл зүйн уламжлалд эрэн сурвалжлагын хэлбэр социализмын үед ч байсан, гэхдээ “тухайн үед сэтгүүлчид мэргэжлээ богино хугацаанд сольж гуанзны үйлчлэгч, таксины жолооч зэргийг хийж, үйлчилгээний байгууллагын ажлыг шүүмжлэхээс хэтрээгүй. Харин шинэ үеийн сэтгүүлчид тийм ч тааламжтай бус орчинд нийгмээс нууцалж байгаа зарим үзэгдлийн мөн чанарыг илрүүлж чаддаг болсон нь ахиц дэвшил” юм.⁹²

Оросын Холбооны Улс. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй бол хамтын бүтээл, хамтын зориг эрмэлзлэл байдаг. Энэ жишгийг Орос улсад үзүүлж, тухайн орны сэтгүүл зүйд эрэн сурвалжлагын үлгэр дууриал, ач холбогдлыг мэдрүүлж байгаа хэсэг сэтгүүлчдийг Санкт-Петербург дэх Андрей Константиновын төв нэгтгэн ажиллаж байна.

Энэ төв нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хувийн агентлаг бөгөөд 40 гаруй сэтгүүлч, цөөн тооны хуульчид ажилладаг. Тус төвийнхөн Төрийн думын гишүүн асан эмэгтэйн гэнэтийн үхлийн шалтгаанаас авахуулаад хэдэн тэрбум төгрөгийн зээл авсан ч үйл ажиллагаа нь дампуурсан барилгын компанийн сүйрлийн араас мөшгин сурвалжилж олон нийтийн анхааралд хүргэжээ.

Тус төв 24 цагаар мэдээлэл авах утас ажиллуулж, эрэн сурвалжлах шаардлагатай гэж үзсэн баримт, хэрэг явдал, сэжиг таамгийнхаа араас сэтгүүлчдийг багаар нь ажиллуулж, үр дүнг нь үзэхийг зорьдог байна. Тэр эрэн сурвалжлага хийх явцдаа шударга ёс, сэтгүүлчийн ёс зүй, нийгмийн ашиг сонирхлыг эрмхэмлэхийг гол шугамаа болгодог яч зарим тохиолдолд улс төр, бизнесийнхний захиалгаар төлбөрт эрэн сурвалжлага хийдэг ажээ. Тухайлбал энэ төвд Финланд, Шведээс тодорхой хэрэг явдлын зангилааг тайлж, эрэн сурвалжилж өгөхийг хүссэн захиалга ч ирж байжээ.

Мэдээллийн эх сурвалжийг нууцлах талаар урьдчилан тохирсон л бол ямар ч нөхцөлд нь хамгаалах ёстой гэдэг зарчмийг тус төвийнхөн мэргэжлийн онцгой эрхээ болгодог байна.

Оросын өнөөгийн сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хандлага байгаа ч хэвлэл, мэдээллийн хэрэгсэл улс төр, эдийн засгийн капитал болон илүүтэй хөгжиж байна. Санкт-Петербургийн их сургуулийн доцент А.А. Юрковын үзэж буйгаар “Өрнөдөд хэвлэл мэдээлэл бизнес болон хувирсан бол Орост гол гол хэвлэл улс төрийн капитал буюу улс төрчдийн засгийн төлөөх тэмцлийн зэвсэг болон илүүтэй ашиглагдаж байгаа” юм.

⁹² <https://mn.wikipedia.org/wiki>

Оросын нэр нөлөө бүхий хэвлэлийг ямар ямар улс төрчид эрхэндээ оруулсныг “Независимая газета” сонин жагсаан хэвлэсэн нь энэхүү сэжиг таамгыг нотолж баталгаажуулсан байна. Орос оронд улс төр, бизнесийнхний мэдээллийн дайн явагдаж буй гэж үздэг судлаачид ч байдаг. Ийм нөхцөлд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжинө гэдэг нь эргэлзээтэй юм. Өөрөөр хэлбэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих таатай хөрс нь бүрдээгүй байна гэсэн үг.

“Мэдээлэл олж авах хууль зүйн бололцоо урьд өмнөхөөс хялбар болсон ч сэтгүүлчдийн хувьд хаалттай бүсүүд байсаар байна. Ялангуяа төрийн эрх баригчдын үйл ажиллагаа ил тод болоогүй, олон түмэнд тайлагнадаггүй, хариуцлагын механизм үйлчилдэггүй учраас эрэн сурвалжилга хийнэ гэдэг нь эрх баригчдын эсрэг сэтгүүлчид нүцгэн гараараа тулалдахтай адил гэж тэд үздэг байна.

Энэ хандлага нь дийлэнхи сэтгүүлчдийг эрэн сурвалжилга, шүүмжлэлт нийтлэл бичихээс зайлсхийх шалтаг болж, тэд дуулиан шуугиан, гэмт хэргийн ертөнц, секс рүү хошуурч, эргээд хэвлэл өөрсдөө шарлаж эхэлсэн байна. Энэ бол Оросын хэвлэлийн сүүлийн арав гаруй жилийн нүүр царай юм. Харин цөөн хэвлэл, цөөн сэтгүүлчид хэн нэгний захиалгаар бус итгэл үнэмшлээрээ ажиллаж, мэргэжлийнхээ нэр хүндийг аврах цаг болсон гэж үздэг ажээ.

Дүгнэлт. Тодорхой хувь хүн болон байгууллага бусдаас ямагт нууцалж байдаг тэр зүйлийн гүнд нь нэвтэрч тэгснээрээ нийгмийн эрх ашгийг хөндсөн чухал асуудлыг дэлгэж тавьсан нийтлэл, нэвтрүүлгийг эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэж тодорхойлдог юм байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь эрх мэдэл бүхий хувь хүн, байгууллагын хууль бус, ёс суртахуунгүй үйл ажиллагаа, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний эсрэг үйлдлийг илчилж олон түмэнд мэдээлдгээрээ нийгмийн хөгжилд чухал хүчин зүйл болжээ.

ОХУ, Филиппин улсуудын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж арга, хэлбэр, туршлагаас үзвэл эрх зүйн орчин хэр сайн бүрдэж, ажиллах бололцоог нь хэрхэн хангасанаас хамаарч, үр дүн нь харилцан адилгүй байдлаар илэрдэг байна.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь томоохон компани, хувь хүмүүсийн эзэмшилд төвлөрч, мэдээллийн агуулгад нөлөөлөх байдал газар авсанаас ихэнхи олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нь үнэн бодитой мэдээлэл олон нийтэд хүргэх явдал учир дутагдалтай болсоор иржээ.

Санал.

1. Манай улсад Филиппиний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв болон ОХУ-ын Андрей Константиновын төв нэртэй эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хувийн агентлагтай нэгэн адил Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нэгдсэн төвийг Монгол Улсад байгуулах

2. Шинээр байгуулах эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нэгдсэн төв нь 24 цагаар мэдээлэл авах утас ажиллуулж, эрэн сурвалжлах шаардлагатай гэж үзсэн баримт, хэрэг явдал, сэжиг таамгийнхаа араас сэтгүүлчдийг багаар нь ажиллуулах

3. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн нэгдсэн төв нь шаардлагатай төсөв хөрөнгөө орон нутг олон улсын төсөл, хөтөлбөрөөр шийдвэрлэх

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр цогц судалгааны ажлыг эрдэмтэн судлаачдын багаар хийлгэж, гарсан үр дүнгээр нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд ашиглах

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЗАМ ХӨДӨЛГӨӨНИЙ ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

*Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн
ахлах дэслэгч Б.Зоригтбаатар
Холбоо барих утасны дугаар: 99627478.
Gereetzorigoo@gmail.com*

Түлхүүр үгс: Зам, зөрчил, жолооч, явган зорчигч, тээврийн хэрэгсэл.

Key words: Traffic, conflict, driver, motor vehicle, passenger.

Хураангуй: Замын хөдөлгөөний зөрчил гэж нийтийн хэрэгцээний зам дээр явганаар болон тээврийн хэрэгслээр хүн, ачаа шилжих үйл ажиллагааг зөрчин хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, Зөрчлийн хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Энэ өгүүлэлд замын хөдөлгөөний зөрчлийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам зэргийг илэрхийлэхийг зорьсон.

Abstract: Traffic violation is an act or mission that violates the law and administrative norms by violating the movement of people and goods by foot and vehicle on public roads, and is punishable by the Law on Violations. . This article aims to explain the causes and conditions of traffic accidents and ways to prevent them..

Нэг. Замын хөдөлгөөний зөрчлийн тухай ойлголт:

Дэлхий нийтийн чиг хандлага болсон автомашинжилт нь нийгмийн хөгжлийн нэг чухал үзүүлэлт болохын зэрэгцээ зам тээврийн осол, зөрчил, хэрэг нэмэгдэж түүнээс учрах хохирол, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө өсч байгаа өнөө үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хэрэг, зөрчлийн шийдвэрлэх асуудал нь дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг хэлдэг бол хууль зөрчих гэж Захиргааны ерөнхий хууль, бусад хууль заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгодог юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй, үйл ажиллагааг зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн этгээдэд шийтгэл хүлээлгэх асуудлыг Зөрчлийн тухай хуулиар тус тус тодорхойлдог.

Бидний хэлж заншсанаар зам тээврийн зөрчил гэдэгт одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 14.7 дугаар зүйлд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон хэм хэмжээг гэм буруутайгаар зөрчсөн үйлдлийг хамааруулдаг.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийн үндсэн шинж нь энэ төрлийн зөрчилд хуулиар тооцогдсон байх, гэм буруутай байх, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг чиглэсэн байх, шийтгэл оногдуулахаар заагдсан байх гэсэн үндсэн шинжийг агуулсанаар зөрчилд тооцогдно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчилд Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн зэрэг нийт 56 үйлдэл, эс үйлдэхүйд хүнийг 10-200 нэгжээр торгох, жолоодох эрхийг 3 сараас 1 жилийн хугацаанд хасч, 7-30 хоногийн хугацаанд албадан сургалтад суулгах, хуулийн этгээдийг 100-1000 нэгж хүртэл торгох шийтгэлийг тус тус оногдуулж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь дэлхий нийтийн өмнө шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болсонтой холбоотойгоор НҮБ-н Ерөнхий Ассамблейн тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 10 жил болгож дэлхий нийтэд тунхагласан байдаг.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх асуудлыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн онолын үүднээс авч үзвэл гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх тухай ойлголт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, гэсэн харилцан шүтэлцээтэй үйл ажиллагааны цогц юм. Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн үүргийн салшгүй нэг хэсэг гэж ойлгож болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн гэж хуульчилсан.

Хоёр.Замын хөдөлгөөний зөрчлийн шалтгаан нөхцөл:

Төр засгаас дэд бүтэц, зам харилцааг сайжруулах, зам засварлах, шинээр барих, авто замын хөдөлгөөнийг телекамерын хяналтад авах зэрэг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсээр байгаа боловч замын хөдөлгөөний зөрчлийн шалтгаан:

- Жолоочийн буруутай үйлдлээс,
- Явган зорчигчийн буруутай үйлдлээс,
- Замын нөхцөлөөс гарсаар байна.

Улсын хэмжээнд 2021 оны 01 дүгээр улиралд бүртгэгдсэн замын хөдөлгөөний зөрчлийн хувьд авч үзвэл. Үүнд:

Хүснэгт:1.



ДУУДЛАГА, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийн 12.7%, хүлээн авсан гомдол, мэдээллийн 22.7%, шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 21.6%, захиргааны зөрчлийн 84.0%-г хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гомдол, мэдээлэл эзлсэн байна.



Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээллийн 12.7%, хүлээн авсан гомдол, мэдээллийн 22.7%, шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 21.6%, захиргааны зөрчлийн 84.0%-г замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийн гомдол мэдээлэл эзэлсэн.

Хүснэгт:2



ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ ТҮҮНИЙ ШИЙДВЭРЛЭЛТ

Захиргааны зөрчилд торгосон хүний 88.1%, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан хүний 100.0%, баривчлах шийтгэлийн 35.4%, торгуулийн дүнгийн 82.8%-г Замын хөдөлгөөний аюулгүй байдлын журмын зөрчилд оногдуулсан байна.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчих зөрчил үйлдсэн этгээдэд торгох, эрх хасах, баривчлах шийтгэл оногдуулдаг. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн торгох 88.1%, эрх хасах 100%, баривчлах 35.4 хувийг тус тус эзэлж улсын төсөвт 10 тэрбум 238 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт:3



ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ ЗӨРЧСӨН ЗӨРЧЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

274.831	ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛСЭН	↓ 44.7%
7243	СОГТУУГААР Т/Х ЖОЛООДСОН	↑ 30.8%
5729	ЖОЛООЧИЙН ЭРХ ХАССАН	↑ 23.3%
1347	ХҮНИЙГ БАРИВЧИЛСАН	↑ 28.9%
29368	ЖОЛООЧИЙН ОНОО ХАССАН	↓ 50.0%
278635	ТОРГОСОН ХҮН	↑ 15.7%
10 тэрбум 238.1 сая	ТӨГРӨГИЙН ТОРГУУЛЬ	↓ 15.9%

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн зөрчлийн үзүүлэлтээр авч үзвэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 7243, жолоочийн эрх хассан 5729, хүнийг баривчилсан 1347, жолоочийн оноо хассан 29368, торгосон 278635 хүн байна.

Үүний шалтгааныг авч үзвэл. Үүнд:

Хүснэгт:4.



Үүнээс үзвэл замын хөдөлгөөний зөрчлийн шалтгааны 98.5 хувийг жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж байгаа бол 1.2 хувийг явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан байна.

Жолоочийн буруугаас гарч байгаа замын хөдөлгөөний зөрчлийн шалтгааныг авч үзвэл хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн, эгнээ байр буруу эзэлсэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, хурд хэтрүүлсэн жолоочийн хөдөлгөөнд оролцох соёл, хууль дүрмийн

мэдлэг сайнгүй, Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлдэггүй, биелүүлэхийг хүсдэггүй, өөрөөр хэлбэл хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэг, хариуцлагыг ухамсарлаж биелүүлэх явдал хангалтгүй, тээврийн хэрэгслийн жолоодох ур чадвар муу байгаатай холбон үзэж болно.

Харин явган зорчигчийн буруугаас шалтгаалсан зөрчил нь биеэ авч явах чадваргүй согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоны улмаас өөрийн амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал гардаг байна.

Замын хөдөлгөөнд оролцож буй явган зорчигчид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль, дүрмийг биелүүлэх нь зөвхөн жолоочид л хамаатай мэтээр ойлгож байгаагаас зам тээврийн осол, зөрчилд өртөх явдал их байна. Сүүлийн 3 жилийн байдлаар зам тээврийн осол, зөрчил, гэмт хэргийн 6.5 хувь нь явган зорчигчийн буруугаас үйлдэлтэй байна. Тухайлбал гарц, гарамгүй газраар зам хөндлөн гарах, гэрлэн дохио зөрчих, тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх, зогсож буй тээврийн хэрэгслийн урдуур нь тойрох, замын зорчих хэсэг болон хашлагыг дагаж явах, архи дан согтуурч замын зорчих хэсэг дээр хэвтэх, унтах зэргээс автомашинд дайрагдаж, шүргүүлэх тохиолдол их байна.

Замын нөхцөл ба техникийн гэмтлийн улмаас гарсан зам тээврийн осол, хэргийн хувьд замын гадаргуу, үзэгдэх орчин, гэрэлтүүлэг чимэглэл тааруу, замын тэмдэг, тэмдэглэл, ойлгомжгүй байснаас болох, тээврийн хэрэгсэлд үүссэнээс хэрэг, осол үйлдэгдэхийг ойлгоно. Энэ нь техникийн бүрэн бүтэн, аюулгүй, найдвартай байдал, түүний тоноглол хамгаалалт, үйлдвэрийн баталгаа, стандарттай холбоотой.

Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол “Буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдний байрлалыг солих, гэрлийн тусгалыг өөрчлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих замаар буруу талдаа жолооны хүрдтэй автомашины тоог цөөрүүлнэ” хэмээн стратеги, төлөвлөгөө баталсан ч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтад сөргөөр нөлөөлж буй нь судалгааны явцад тогтоогдсон гэж үзэж болох юм.

Замын хөдөлгөөн шуурхай байх үндсэн нөхцлийг нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөх шаардлагатай. Замын эвдрэл гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцөлүүдийн нэг болдог байна.

Дүгнэлт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахад замын чанар, замын нөхцөл гэрэлтүүлэг, явган хүний зам, гарцыг сайжруулах, унадаг дугуйн замтай болох нь чухал гэж үзэж байна. Судалгаанаас үзэхэд замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд явган зорчигч гарцгүй газраар, автомашин улаан гэрлээр гарах зөрчил зонхилж байна.

Замын хөдөлгөөний зөрчлийн талаар явган зорчигч, жолооч нарын мэдлэг сайнгүй, мэдлэгийн түвшинд хүйс, жолоо барьсан жил нөлөөлөхгүй байгаа боловч боловсролын түвшин дээшилж, эмэгтэйчүүдийн нас ахих тусам мэдлэгийн түвшин сайжирч байна.

Явган зорчигчдын ихэнх нь замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж, зам хөндлөн гарч болно гэсэн буруу хандлагатай байсан бол жолооч нарын дунд согтуугаар жолоо барих, суудлын даруулга бүс хэрэглэхгүй, замын гэрэл дохиог мөрдөхгүй, хурд хэтрүүлж болно гэх мэт буруу ойлголт, хандлага зарим жолооч, зорчигч нарт байна.

Жолооч нарын түгээмэл гаргадаг зөрчил нь орчныхоо машинтай хэт ойр явах, явган зорчигч нарт зам тавьж өгдөггүй, согтуугаар тээврийн хэрэгсэл жолооддог, шар гэрлээр хөдлөх, бүрэн бус техник жолоодох зэрэг байна.

Замын хөдөлгөөний зөрчлийг жолооч, явган зорчигчид адил хэмжээнд их гаргаж байна. Тухайлбал улаан гэрлээр явах, зөвшөөрөгдөөгүй газраар зам гарах, жолооч хөдөлгөөнд оролцож явахдаа утсаар ярих, суудлын бүс хэрэглэхгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл барих зөрчил их байна.

Тээврийн цагдаагийн алба нь дунд болон урт хугацааны стратеги төлөвлөлтийг хийж боловсон хүчин хүний нөөцийг төлөвлөх шаардлагатай.

Алба хаагчдын ажлын байрны тогтвортой байдал, албан тушаал ахих шатыг тодорхой болговол алба хаагчид албандаа итгэх итгэл, тодорхой зорилго, зорилттой болох талтай.

Хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, осол, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн байдалд дүн шинжилгээ хийж зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоон зөв оновчтой сонгож зохион байгуулах шаардлагатай байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн зөрчлийн үзүүлэлтээр авч үзвэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 7243, жолоочийн эрх хассан 5729, хүнийг баривчилсан 1347, жолоочийн оноо хассан 29368, торгосон 278635 хүн байна. Замын хөдөлгөөний зөрчлийн шалтгааны 98.5 хувийг жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалж байгаа бол 1.2 хувийг явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан.

Санал:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулахын тулд зам, замын байгууламжийг сайжруулж, явган зорчигч, жолооч нарын замын хөдөлгөөнд оролцох аюулгүй орчныг бүрдүүлэх зориудын арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх,

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй хэвшил дадлыг өөрчлөх, зөв мэдээлэл өгөх сургалт, сурталчилгааны ажлыг хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцүүлэн ялгавартайгаар зохион байгуулах, ялангуяа хүүхдэд бага наснаас нь замын хөдөлгөөний боловсрол олгох ажлыг Ерөнхий боловсролын сургуулийн сургалтанд албан боловсролын хэлбэрээр оруулах замаар шийдвэрлэх,

3. Олон улсын болон улсын чанартай замыг хатуу хучилттай болгох, замын тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэг, хурд сааруулагч, замын голын хашлага, гарамыг оновчтой байрлуулах ажлыг эдийн засаг зохион байгуулалтын арга хэмжээний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг санхүүжүүлэх. Тухайлбал жолооч бэлтгэх сургалтын төвийг байгуулах, шинээр бэлтгэгдэн гарч байгаа алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зэрэг ажилд зарцуулах.

5. Хүүхэд сургуульд аюулгүй очих, ирэх сургалтын хөтөлбөрийг дэмжих. Сургууль, цэцэрлэгийн орчны замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулсан зам, тоноглолыг иж бүрдлийг ханган, хөдөлгөөн зохицуулах, хяналт шалгалт хийж байх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах.

6. Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр бүртгэгдсэн замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийн бичлэг, фото зургийг үндэслэн зөрчил гаргагчид зөрчлийн шийтгэл оногдуулах төсөл боловсруулж хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд цаашид гудамж замын хөдөлгөөний хяналт зохицуулалтад техникжүүлэлт, камержуулалт, автомашинжуулалт, компьютержуулалтыг цогцоор нэвтрүүлэх.

7. Орон нутгийн босоо, хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай замын дагуу 150 километр тутамд хяналтын постыг байгуулах. Пост байгуулах, техник хэрэгслээр хангаж үйл ажиллагааг хэвийн явуулахыг орон нутгийн Засаг дарга нарт чиглэл өгч, хэрэгжүүлэх.

8. Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол “Буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн хүрдний байрлалыг солих, гэрлийн тусгалыг өөрчлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих замаар буруу талдаа жолооны хүрдтэй автомашины тоог цөөрүүлнэ хэмээн баталсан стратеги, төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх, үр дүнд хүрэх.

Ашигласан материал:

1. Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2017,
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2015,
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2019,
4. Цэдэндамба.Б, Болор-Эрдэнэ.Ц. Зөрчлийн эрх зүй. УБ., 2019
5. Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоол.
6. <https://transportation.police.gov.mn/a/4218>